

05 дугаар сарын үйл ажиллагааны мэдээ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Хууль зүй дотоод хэргийн яамны дэд сайд С.Баатаржаваар ахлуулсан ажлын хэсэг тус аймагт ажиллав. Энэ үеэр аймгийн Онцгой комиссын дарга, аймгийн Засаг дарга М. Идэрбат, ЭМГ-ын дарга Б. Гантулга нар тулгамдаж буй асуудлаа танилцуулж, цар тахлын үед авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ, цаг үеийн асуудлаар мэдээлэл хийлээ. Дэд сайд С. Баатаржав Сүхбаатар аймаг коронавируст халдвар цар тахал болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ сайн байгаа гэдгийг онцолсоны зэрэгцээ хууль зүйн асуудлын эрхлэх хүрээний аж ахуй нэгжийн үйл ажиллагаатай танилцаж хамтын ажиллагаа хэвийн хэмжээнд байгааг тэмдэглэн хэллээ.

МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар энэ жил Сүхбаатар аймгийн 237 ээж "Алдарт эх"-ийн, одонг хүртжээ. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр Эх үрсийн баярыг тохиолдуулан Баруун-Урт сумын 81 ээж 05 сарын 31-ний өдөр одонгоо гардаж авлаа. Аймгийн хэмжээнд "Алдарт эх"-ийн нэгдүгээр зэргийн одон 12, ихэр хүүхэд төрүүлсэн 11 ээж, хоёрдугаар зэргийн одонг 225 ээж хүртжээ. "Алдарт эх"-ийн хоёрдугаар зэргийн одонг 25 настай ээж хүртсэн нь хамгийн залуу ээж болж байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төрийн байгууллагын ажиллах нөхцөл, техник технологийг сайжруулах зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газарт цахим техник тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийг зарлаж, улмаар тендерт шалгарсан "Монтек" ХХК-аас тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлын хэсгийг ТЗУХ-ийн даргаар ахлуулан байгуулсан. Мөн аймгийн вэб сайтыг шинэчлэх ажлыг "Номадик контент" ХХК-аар гүйцэтгүүлж байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу аймгийн хэмжээнд "Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем ERP"-ийг нэвтрүүлж байгаатай холбогдуулан уг системийн ашиглалтын талаарх сургалтыг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн өмчийн байгууллагуудын 140 албан хаагчийг хамруулан зохион байгуулав. Уг системийг 36 байгууллага нэвтрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна. Түүнчлэн 185 төрийн албан хаагчдад Төрийн байгууллагын цахим шуудан webmail олгосон байна.

Аймгийн хэмжээнд E-Mongolia төрийн үйлчилгээний оператороор 266 иргэн үйлчлүүлж лавлагаа үйлчилгээ авсан байна.

Энэ сард аймгийн Засаг даргад 5 өргөдөл гомдол ирсэнийг шийдвэрлэсэн. Үүнээс 2 иргэний эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлж 1.5 сая төгрөгийг Засаг даргын нөөцөөс олгон шийдвэрлэсэн.

Төрийн одон медаль тодорхойлогдсон нийт 30 иргэний материалыг хүлээн авч хянан аймгийн ИТХТ-дэд уламжиллаа. Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон-1, Алтан гадас одон-12, Хөдөлмөрийн хүндэт медаль-17 иргэний материал ирсэн байна.

Мэдээлэл сурталчилгаа: 04 дүгээр сарын 31-нээс 05-р сарын 28 хүртэлх хугацаанд аймгийн ЗДТГ-ын цахим хуудас 1758 хүнээр нэмэгдэж, 126,469 хүнд мэдээлэл хүрсэн байна.

Коронавируст халдвар ковид 19 нөхцөл байдлын мэдээллийг шууд лайваар 36 удаа, 38 удаагийн текстэн мэдээллийг бэлтгэж, аймгийн томоохон групп болон сумдын группт тавьж олон нийтэд мэдээлэл хүргэв.

Цаг үеийн нөхцөл байдлын мэдээлэл болон уул уурхайн үйл ажиллагаа, замын бүтээн байгуулалтын явц, мод тарилт зэрэг нийт 187 удаагийн видео болон цахим мэдээллийг

бэлтгэж хүргэсэн байна.

05-р сарын 12-нд аймгийн Засаг дарга болон холбогдох хэлтсийн дарга нартай хамт Цахиурт Эм Эл овоо ХХК-тай цаг үеийн нөхцөл байдалтай танилцаж, цаашид хамтран ажиллах чиглэлээр харилцан ярилцлаа.

Засаг даргын орлогч Г.Мөнхзаяа, МХГ-ын эрүүл ахуй халдвар хамгааллын улсын хяналтын байцаагч нар Баяндэлгэр, Халзан, Түмэнцогт суманд вакцины хяналтаар ажиллав. Засаг даргын Тамгын газраас бэлтгэн хүргэдэг “Төрийн мэдээллийн цаг” нэвтрүүлгээр ХОХБТХ-ийн дарга 2021 онд хийгдэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын талаар, аймгийн ЗДТГ-ын Байгаль орчин аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн, БОАЖГ-ын мэргэжилтэн нар Ногоон байгууламж нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар, аймгийн ЗДТГ-ын Боловсрол, Гэр бүл хүүхэд, залуучууд хариуцсан мэргэжилтэн, БСУГ-ын дарга нар ЭЕШ-ын бэлтгэл болон төгсөх ангийн сурагчдын танхимаар давтлагад хамруулах, анхаарах асуудлын талаар тус тус мэдээлэл өгөв.

Улсын аварга малчин өрх болон улсын хошой аварга малчдад шагнал гардуулах арга хэмжээг 8 малчны хотноос 2 сурвалжлагыг бэлтгэж орон нутгийн телевизээр нэвтрүүлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн орон нутгийн онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал, журам боловсруулах төслийг боловсруулан ажиллаж байна. Энэ хүрээнд сум, агентлагт албан бичиг хүргүүлэн журмын төсөлд санал авч, улмаар агентлаг байгууллагын дарга, холбогдох мэргэжилтнийг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авах ажлыг зохион байгууллаа.

13 сум, 27 агентлагийн 2020 оны тайланг архивын нэгж үүсгэн архивлан цэгцлэж, нийт 16 архивын баримыг байгууллагын архивт хүлээлгэн өглөө.

“Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт-хяналт, шинжилгээ үнэлгээ” сургалтанд хамрагдсан төрийн албан хаагчдын мэдээллийн нэгтгэлийг сумд болон агеттлаг, төсөвт байгууллагаар гаргаж хамрагдалтыг идэвхижүүлэн ажиллаа. Аймгийн хэмжээнд нийт 950 төрийн албан хаагч хамрагдсан байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2020 онд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр бүрэн хэрэгжсэн, нэг удаагийн шинжтэй, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй заалтуудыг хяналтаас хасуулах саналаа ЗГХЭГ-ын үнэлгээний цахим системийн “хүчингүй болсон буюу хяналтаас хассан тухай тэмдэглэл” хэсэгт тайлагнаж баталгалжуулсан.

Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:

2021 оны 5 дугаар сард улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр болон тусгай зориулалтын шилжүүлгийн орлогоор нийт 17,520.2 сая төгрөг авч, орон нутгийн төсөвт 3,573.3 сая

04-ний өдрийн 10/11 дугаар тогтоолоор “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу 20 байгууллагаас ирсэн саналын дагуу хөрөнгийг нүд үзэж тоолон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд оруулахаар 7 байгууллагын 11 хөрөнгийг худалдах, 4 байгууллагын 114 хөрөнгийг шилжүүлэх, 8 байгууллагын 26 хөрөнгийг актлах, 1 байгууллагын нэр дээр 2 хөрөнгийг бүртгэхээр тогтоолын төсөл хүргүүлээд байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 18 дугаар тогтоол “Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” журмын дагуу шүүхийн шийтгэх тогтоолоор хураагдсан 3 хөрөнгийн нээлттэй дуудлагыг 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, 1 хөрөнгө 1,850,000 төгрөгөөр зарагдсан байна.

Өмчийн бүртгэл, хяналтын чиглэлээр: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 10/11 дугаар тогтоолоор “Орон нутгийн өмчид эд

хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын дагуу 20 байгууллагаас ирсэн саналын дагуу хөрөнгийг нүд үзэж тоолон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд оруулахаар 7 байгууллагын 11 хөрөнгийг худалдах, 4 байгууллагын 114 хөрөнгийг шилжүүлэх, 8 байгууллагын 26 хөрөнгийг актлах, 1 байгууллагын нэр дээр 2 хөрөнгийг бүртгэхээр тогтоолын төсөл хүргүүлээд байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 18 дугаар тогтоол "Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" журмын дагуу шүүхийн шийтгэх тогтоолоор хураагдсан 3 хөрөнгийн нээлттэй дуудлагыг 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, 1 хөрөнгө 1,850,000 төгрөгөөр зарагдсан байна.

Хяналт шалгалтын чиглэлээр: Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж түүнийг үндэслэн Төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон дүрэм, журам, стандартын биелэлт, хэрэгжилтэнд хяналт тавьж, тухайн байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад дүгнэлт өгөх илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжлийн заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Халзан сумын Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн санд санхүүгийн хяналт шалгалт, Халзан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Соёлын төв, Халзан дулаан ОНӨААТҮГ-д дотоод аудитын шалгалтууд тус тус хийгдэж байна. Мөн өмнө хийгдэж байсан шалгалтууд дууссан.

2021 оны эхний 5-н сард хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар нийт 229752.9 мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрсэнээс 6 салбар актаар 8536.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, 221216.9 мянган төгрөгийн зөрчилд хугацаатай 6 албан шаардлага өгч ажиллалаа. Дотоод аудитын шалгалтаар илэрсэн зөрчилд хугацаатай зөвлөмж өгч ажилласан байна.

Гурав. Нийгмийн бодлогын хүрээнд:

Боловсролын чиглэлээр: Боловсрол, шинжлэх ухааны яамнаас зохион байгуулсан "ЕБС-ийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хууль", "Хөрөнгө оруулалтын ажил", "ЕБС-д сэтгэл зүйч ажилуулах асуудлаар санал солилцох уулзалт" зэрэг уулзалт семинарт аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын орлогч нар, Үндэсний хөгжлийн газраас зохион байгуулсан "Монгол Улсын хүнсний тогтолцооны асуудлаарх бүс нутгийн хэлэлцүүлэг"-т Нийгмийн бодлогын асуудал хариуцсан албан тушаалтнууд оролцож, салбар хуралдаанаар тус тус санал солилцлоо.

Төрийн мэдээллийн цаг нэвтрүүлгээр "ЭШ-д оролцогчдод танхимын сургалт явуулах журам" –ыг танилцуулж, орон нутгийн мэдээллийн хэрэгслээр хүргэлээ.

Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан Сүхбаатар аймгийн яруу найрагчид зохиолчдынхоо бүтээлээс сэдэвлэсэн "ЖААХАН ШАРГЫН НУТАГ" монгол бичгийн онлайн уралдааныг зохион байгуулж, "Үзгийн хичээнгүй бичиг", "Бийрийн хичээнгүй бичиг", "Уран бичлэг", "Таталган бичиг" төрөлд 39 байгууллагын 390 албан хаагч, 15 сургуулийн 225 сурагчийн хичээнгүй бичвэр, мэргэжлийн 46 багшийн хичээнгүй бичвэр, тайлан, 40 гаруй уран бүтээлчийн бүтээлийг хүлээн авч нийт 4 төрөл 4 ангиллаар 21 байр шалгаруулж урамшууллаа.

Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зохион байгуулж буй "Ирээдүйн амжилтын эзэд" нэвтрүүлгийн зураг авалтад 3 хүүхэд оролцууллаа.

Мод тарих өдрийг тохиолдуулан аймгийн боловсролын салбарын 41 байгууллага өөрийн эзэмшлийн талбайд 17 төрлийн 8927 мод бут тарьж 3760 м2 тайлбайг зүлэгжүүлсэн. Байгууллагын гадна болон дотоод орчинд 24 төрлийн 2596 мандлын болон тасалгааны цэцэг

тарьжээ. Мөн 2093 м2 талбайд хүлэмж байгуулан 17 төрлийн хүнсний ногоог тариад байна.

Орчин цагийн боловсролын салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойд зориулан Баруун-Уртын боловсролын салбарын 18 байгууллага болон НТБ төв, БСУГазар Боловсрол төгөлд нийт 2263 ширхэг мод тариалж “Ногоон төгөл” байгуулсан бөгөөд аймгийн хэмжээнд сургууль цэцэрлэгүүд нийтийн эзэмшлийн тайлбайд нийт 4599 ширхэг мод бут тарьсан.

"ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨХ ХАМТЫН САНААЧИЛГА, ТҮНШЛЭЛ" нэгдсэн онлайн арга хэмжээнд Боловсролын салбарын багш удирдах ажилтнууд 7 чиглэлээр оролцож "ТХБ 2030"-ын үйлийн тэргүүлэх 5 чиглэл, тэдгээрийг хэрэгжүүлэх менежментийн талаар мэдээлэл авч санал бодлоо илэрхийлсэн. СӨБ-ын мэргэжилтэн БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА-СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ, ТЕХНОЛОГИЙН ХӨГЖИЛ" сэдэвт и-форумд оролцсон.

СӨБ-ын Бэлтгэл бүлгийн хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах чиглэлээр мэргэжлийн багш нартай 5 удаагийн онлайн уулзалт хийж арга зүйн чиглэл өгч ажиллаа. Аймгийн 24 цэцэрлэгийн 4 бүсээр зохион байгуулж Бэлтгэл бүлгийн хүүхдэд чиглэсэн дасгал ажлыг 3 гарын авлага, эцэг эхэд зориулсан зөвлөгөө зөвлөмж боловсруулан хүргэх үйл ажиллагааг зохион байгууллаа. СӨБ-ын мэргэжилтэн "Төсөлд суурилсан арга зүй" сэдэвт онлайн сургалтыг зохион байгуулж 131 эрхлэгч, арга зүйч, багш нарыг хамруулсан.

Xreading цахим номын сангийн танилцуулга сургалтад 40 багш, админ эрхийн сургалтанд 15 багш хамрагдаж, багшийн хөгжлийг дэмжих зорилготой 540 000 төгрөгний шагналын сантай багийн 21 хоногийн хугацаатай "Уншлагын марафон" зохион байгуулж нийт 45 багш хамрагдаж 7 хоног 30 000-100 000 гаруй мянган үг уншиж, 10-с дээш цаг сонсголоо сайжруулж мэдлэг мэргэжлээ дээшлүүлж байна.

Англи хэлний багш нар ЭЕШ-ын бэлтгэлийг эрчимжүүлэх зорилгоор 7 хоног тутам сорил авч дүнг нэгтгэн танилцуулж Зөвлөмж хүргүүлж байна. Мөн нөхцөл байдал хүнд байгаа Онгон сумын сурагчдад тэргүүлэх зэрэгтэй туршлагатай багш нараар 7 хоногт 1 удаа зүүм хичээл төлөвлөн заалгаж байна. 5-р сарын 14-ны мэдээгээр Теле хичээлийн хамрагдалт 70 хувьтай, Хэвлэмэл материал 1638 ширхэг, нэмэлт цахим хичээл-1448, Зүүмээр холбогдож байгаа багш -456 буюу нийт багш нарын 70 гаруй хувь нь сурагчидтайгаа тогтмол холбогдон ажиллаж байна.

Хүүхэд хамгааллын мэргэжилтэн "ХҮҮХЭД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ" С002/2020 төслийн хүрээнд зорилтот Сүхбаатар, Сэлэнгэ, Увс аймаг, Налайх, Сонгинохайрхан дүүргүүдийн Сургуулийн багш, ажилчид Хамтарсан баг, НЦҮ, ХБ, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг ажилтнуудын дунд зохион байгуулсан сургалтад хамрагдсан байна.

БШУ-ны сайдын А/171 дугаар тушаалын дагуу 2021 оны 05 дугаар сарын17-ны өдрөөс 12-р ангийн сурагчдын давтлагыг халдвар хамгааллын дэглэм баримтлан эхлүүлсэн. Давталгад ЭЕШ-д бүртгүүлсэн нийт 612 шалгуулагчийн 96.7% буюу 592 суралцагч 10 судлагдахуунаар хамрагдаж байна. Онгон сумын сургууль эрсдэлтэй байгаа тул цахимаар давтлага өгч байна. Элсэлтийн ерөнхий шалгалтад Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 612 төгсөгч, өмнөх оны 112 төгсөгч нийт 724 суралцагч 10 судлагдахуунаар шалтгалт өгөхөөр бүртгүүлсэн.

Сүхбаатар аймгийн ГБХЗХГ, Сүхбаатар аймгийн Боловсрол соёлын газар Үжин төвийн Ундраа багштай хамтран Аймгийн нийт сургуулиудын АУБагш нарт хүүхэд хамгааллын чиглэлээр цахим сургалтыг 04 сарын 30наас 05 сарын 09-ний өдөр зохион байгууллаа. Сургалтанд АУБ нар болон сургуулийн нийгмийн ажилтнууд нийлсэн 453 багш ажилтнууд хамрагдсан байна.

Ковидын эсрэг вакцинжуулалтын 1-р тунд салбарын хэмжээнд 1768 албан хаагчдаас 1612 албан хаагч буюу 91,2%-тай, 2-р тунд 1512 албан хаагч 85,5% хамрагдлаа. Ахлах ангийн 18 -аас дээш насны нийт 715 сурагчдаас 699 буюу 97,8%, үүнээс 12-р ангийн 665 суралцагч буюу 97,7% Ковидын эсрэг вакцинжуулалтын 1-р тунд хамрагдсан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: энэ сард 6 кейст нөхцөл байдлын үнэлгээ хийж, үйлчлүүлэгч нарт холбогдох үйлчилгээг үзүүлж, харъяаллын дагуу хамтарсан багт шилжүүлэн хяналтанд авсан. Баруун-Урт сумын хамтарсан багт кейс конференци зохион байгуулж, 6 кейс үйлчилгээг хаасан.

Гэр бүлийн асуудлаар 1 үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж түр хамгаалан байрлуулах үйлчилгээг /нөөц өрөөнд/ үзүүлж ажиллаж байна.

Олон Улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Аав&Би” телевизийн нэвтрүүлгийг хийсэн.

Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн дарга нартай цахим уулзалт зохион байгуулж, ажлын чиглэл болон цаг үеийн асуудлаар санал солилцож ажиллалаа.

ХБХЭМБНХМК-ын хурлаар 13 хүүхдийн асуудлыг хэлэлцэж 1 хүүхдийг шинээр тогтоож, 12 хүүхдийн асаргааны тэтгэмжийг сунгалт хийгдсэн.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Ерөнхий боловсролын 16 сургуулийн Анги удирдсан багш нарт “Хүүхэд хамгаалалд анги удирдсан багшийн үүрэг, оролцоо” онлайн сургалтанд 453 хүүхэд хамруулсан.

Хүүхдийн амьдралын бүхий л талбарт хүүхдийн оролцоог тодорхойлох, хүүхдийн төлөө хийж байгаа ажлуудыг хүүхдийн нүдээр харж, үнэлэх, тэдэнд тулгамдсан асуудлыг бодлого шийдвэрт тусгах зорилгоор зохион байгуулсан “Оролцоод хөгжье” цахим чуулганыг зохион байгуулж 150 хүүхэд оролцож, үе тэнгийнхнээ төлөөлж оролцлоо.

“Хайрын түүх” нэвтрүүлгийн 5 дахь дугаарыг бэлтгэн байгууллагын цахим хуудас болон орон нутгийн телевизээр олон нийтэд хүргэлээ.

“ЗАЛУУЧУУДЫН ӨДӨР”-ийг тохиолдуулан нийт залуучуудад чиглэсэн “Амжилтын жор”, “Жендэр, жендрийн тухай үндсэн ойлголт” сэдэвт цахим сургалтуудыг зохион байгуулсан. Нийт 104 хүн хамруулсан.

“GOOD DEEDS DAY” арга хэмжээний хүрээнд “Сайн үйлсийн өдөр Монголд” үндэсний цахим конференцид залуучуудыг хамруулсан.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, цахимаар дамжуулан өсвөр үе, залуучуудын дасгал хөдөлгөөнөөр дамжуулж тэдний эрүүл мэндийг дэмжих, нийгэмд эерэг уур амьсгал бүрдүүлэх зорилгоор иогийн хичээлийг нэг сарын хугацаатай 12 насанд хүрэгчид, 27 өсвөр үе, залуучуудад мэргэжлийн багштай хамтран зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/272 дугаар захирамжаар байгуулагдсан Засаг даргын дэргэдэх Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн анхдугаар хуралдааныг зохион байгуулж, 2021 оны төлөвлөгөөг батласан ба залуучуудын элчээ тодруулж, улмаар нэг залуу гэр бүлийг орон байраар хангах шийдвэр гаргалаа.

“Дэлхийн мөнгөний долоо хоног”-2021 аян хүрээнд ахлах ангийн сурагчдад “Мөнгөө хэрхэн удирдах вэ”, “Хувь хүний ба өрхийн төсөв”, “Зардал ба хуримтлал”, “Цахим мөнгө” сэдвүүдээр сургалт зохион байгуулсан. 3R Хүүхэд, гэр бүл, залуучуудын эрх, үүрэг, оролцоо сургалтыг 1 байгууллагад зохион байгуулж, 23 хүнийг хамруулсан.

Хөгжимт жүжгийн театр: Боловсрол, соёл урлагийн газраас зохион байгуулсан үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд Сүхбаатар аймгийн яруу найрагчид зохиолчдынхоо бүтээлээс сэдэвлэсэн “ЖААХАН ШАРГЫН НУТАГ” монгол бичгийн уралдаанд Тэргүүн байр эзэлсэн.

Уран бүтээлчдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх мөн сурталчлах зорилгоор 14 хоногийн турш “Би мэргэжилдээ хайртай” аяныг зохион байгуулж 5 сарын 20-нд шалгаруулж дууссан. Уг аян чанарын шаардлага хангасан бүтээлийг цахим хаягтаа байршуулж шалгарсан уран бүтээлчийн бүтээлийг олон нийтийн сүлжээнд байршуулах юм.

Нийтийн номын сан: МУГЗ Г.Мэнд-Ооёогийн нэрэмжит Сүхбаатар Аймгийн Нийтийн номын сангийн пэйж хуудсанд: Эх хэл тусгаар тогтнол мэдээлэл булан ажиллуулж: "Цахим орчинд соёл түгээе, Хүн бүр Үндэсний бичиг үсгээрээ уншиж, бичиж чаддаг болохын төлөө Та бүхэн уншаад comment хэсэгт уншсанаа бичээрэй, мөн уншуулах хүнээ mention хийгээрэй...Баярлалаа Бид гэртээ... Номтой нөхөрлөө, Соёл Түгээе, Би Хариуцлагатай Иргэн Соёлын Яам бичвэр өглөө бүр оруулан түгээн сурталчилж байна. Энэхүү ажлын гол

зорилго нь үндэсний бичиг соёлын өвөө түгээн дэлгэрүүлэх, хүүхэд залуус уншигчдад бүтэн жилийн турш уйгаржин бичгийг сурталчилж, тэдний сурах, унших идэвхийг өрнүүлэхэд оршино. Одоогийн байдлаар энэхүү постод нийтдээ фото зургаар 236 мэдээлэл оруулахад 6350 хүн хандалт өгсөн байна.

Лавлагаа, номзүйн үйлчилгээ: Лавлагаа ном зүйн үйлчилгээний хүрээнд цахим хуудсаар нэг сарын хугацаанд 3156 удаа пост оруулан ажилласан байна. 16120 хүн хандалт өгсөн мэдээтэй байна. Байгууллагын цахим хуудсуудаар өглөө бүр цаг үеийн байдал, цахим ном, байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, цахимаар явуулж байгаа уралдаан сурталчлан түгээх, цар тахлын сэрэмжлүүлэг гэх мэт төрөл бүрийн мэдээллийг оруулан шуурхай ажилладаг.

Сүхбаатар аймгийн Нийтийн номын сан fb хуудсаар Нутгийн найрагч буланд “Тал нутгийн найргийн аян”-д нэгдсэн 40 гаруй уран бүтээлчдийн бүтээл болон ахмад үеийн найрагчдын бүтээлээс тогтмол үргэлжлүүлэн бичвэрээр оруулан цаашид үргэлжлүүлэн хөтлөх саналыг аван ажиллаж байна.

Шинээр Найргийн хур- Сэтгэлийн дархлаа булан хөтөлж Монголын яруу найрагчдын шүлэг яруу найргаар мэдээлэл тогтмол оруулж нийтдээ 20 гаруй уран бүтээлчдийн 30 гаруй шүлэг найргаар лавлагаа өгөн тогтмол ажиллаж байна.

ЦАХИМ ПРОГРАММ ХАНГАМЖ: Хорио цээрийн улмаас Lib4 net программ хангамжид Дьюгийн ангилалаас ББК ангилалруу 320 гаруй номын ангилал солин ажиллалаа.

2021 оны хагас жилийн татан авалтаар 76 нэр төрлийн 150 ширхэг номыг бүртгэн ажиллаж байна.

Цахим хуудсанд 2 видео, нутгийн хүүхдийн зохиолчийн шүлэг 20, нийт 29 мэдээлэл оруулсан. Мөн дэлхийн хүүхдийн номын өдөр 10 мэдээлэл оруулсан.

Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан “АЗ ЖАРГАЛТАЙ ХҮҮХЭД НАС” уралдааныг зарлан бүтээлийг файлаар аван ажиллалаа. Тус хугацаанд бүтээлийг чатаар хүлээн аван эцэг эх, ах эгч хүүхдүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн нэгдсэн гэрээт тогтмол сурталчлан ажилласны үр дүнд тус уралдаанд нийтдээ 30 гаруй хүүхэд бүтээлээ ирүүлэн идэвхтэй оролцлоо.

Монгол эх хэл, бичиг үсэг, түүх, соёлын дурсгалаа судлах, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд иргэд, олон нийтийн идэвхийг өрнүүлэх, монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх үндэсний аяныг зохион байгуулах, монгол бичгийн судалгаа, сурталчилгааг өргөжүүлэх үйл ажиллагааг дэмжих, соёлын өвийг хадгалах, хамгаалах, судлах зорилгоор **ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯРЫН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН #МОНГОЛ_БИЧИГ_ҮНДЭСНИЙ_ДАРХЛАА** ЦАХИМ CHALLENGE УРАЛдаан зохион байгууллаа.

Угсаатны зүйн музей: Олон улсын музейн өдрийг тохиолдуулан “БИД ТАЙЛБАРЛАГЧ” бичлэгийг хийлгэн өөрийн хуудаснаа байршуулсан.

Цахим хуудаснаа үзмэр эд өлгийн зүйлээ сурталчилан таниулж ажиллаж байна. Шинэ музейн үзэл хүрээнд үзмэрийн нарийвчилсэн судалгааг гаргаж регистр програмтай тулгалт хийж дууссан.

Соёлын өвийн тухай ойлголт, Баруун урт дахь хөшөө дурсгалт хичээл бэлтгэж сурталчилсан. Соёлын өвийн эрх зүйн сургалт хичээл бэлтгэж ажилласан

Дарьганга өв соёл сэтгүүлийг танилцуулгыг цахим хуудаснаа байршуулж ажилласан.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын чиглэлээр: Коронавируст халдварын цаг үеийн нөхцөл байдлын мэдээллийг өдөр бүр орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр иргэдэд хүргэж Коронавируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар анхан шатны эмнэлгүүдэд 3 удаа цахимаар сургалт зохион байгуулж тусгаарлах байранд дэмжлэгт хяналт хийн арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

PCR шинжилгээний сорьцыг ХӨСҮТ-д 3 удаа 170, Хэнтий аймагт 4 удаа 110, Дорнод аймгийн бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2 удаа 145ш тээвэрлэсэн байна. Мөн

Коронавируст халдварыг илрүүлэх PCR-ийн шинжилгээг АНЭ-т туршилт баталгаажуулалт хийж эхлээд байна.

Коронавируст халдвар тархах эрсдэлийн 1 дэх шатны үнэлгээг Тохиолдлын удирдлагын тогтолцооны багуудтай хамтран Онгон суманд цахимаар хийн тус сумын онцгой комисс болон Аймгийн шуурхай штабт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар чиглэлийг хүргүүлсэн.

Коронавирусийн халдварын үед нэн шаардлагатай вирусийн эсрэг эмийн хэрэгцээг тооцоолон гаргаж нийт 1690 ширхэг Арбидол эмийг татан авч АНЭ-т олгоод байна.

Ковид-19-ын эсрэг 85903 хүн тун вакциныг мэргэжлийн байгууллагуудын хяналтан дор хувиарлан дархлаажуулалтын үйл ажиллагааг 18 түр цэгээр зохион байгуулж байна.

Аймгийн хэмжээнд: 1-р тунгийн хамрагдалт 89.8%, 2-р тунгийн хамрагдалт 21,8%-тай байна.

Халдвар бүртгэгдсэнээс хойш гадна талбайд 546 475 дотор 677 293 нийт 1 223 768 МК талбайд халдваргүйжүүлэлт хийсэн байна.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч нарт хүүхдийн өвчлөлийг бууруулах, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ, чанар хүртээмжийг дээшлүүлэх цахим сургалт, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газартай хамтран “Хөдөө орон нутагт ажиллаж байгаа эм зүйч, эм найруулагч нарын тулгамдаж байгаа асуудал, эмийн эргэлтийн сангийн өнөөгийн байдал сэдвээр цахим хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох комиссын хурлыг зохион байгуулж 7 байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгаж, 1 байгууллагад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар олголоо.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Уламжлалт анагаах ухааны төвд автомашин худалдан авах гэрээний дагуу хүлээлгэн өглөө.

Коронавируст халдварыг илрүүлэх оношлуур, тоног төхөөрөмж худалдан авахад аймгийн Засаг даргын нөөц сангаас 16260 төгрөгийг гаргалаа.

Нийгмийн даатгалын чиглэлээр: 2021 оны 05 сарын 17 өдөр Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харъяа Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021-2023 онд хамтран ажиллах “Санамж бичиг”-т гарын үсэг зурлаа.

2021 оны 05 сарын 21 өдөр НДЕГазраас зохион байгуулсан “Нийгмийн даатгалын сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтнүүдийн социал маркетингийн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийттэй харилцах цахим сургалт”-д сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтнийг хамрууллаа.

2021 оны 05 сарын 24-28-ны өдөр НДЕГазраас зохион байгуулж байгаа “Сумдын нийгмийн даатгалын байцаагчдын цахим сургалт” –д 12 сумын 13 байцаагч, хэлтсийн дарга, сургалт сурталчилгааны мэргэжилтэн хамрагдаж байна.

2021 оны 12 сарын 31-ний байдлаар тэтгэврийн зээлгүй байсан болон сая хүртлэх зээлтэй байсан тэтгэвэр авагчдад “Эрдэнэс бонд” үнэт цаасыг тараах ажил хийгдсэн. 2021 оны 05 сарын 21-ны байдлаар нийт 4125 үнэт цаасыг тараасан нь 84%-тай байна. Холбогдох дансанд мөнгө нь байршсан.

Хөдөлмөрийн зах зээлийн талаар: 05-р сарын 24-ний байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 657 иргэнээс эмэгтэй 297, бүртгэлтэй ажилгүй 540 иргэнээс, эмэгтэй 189 иргэн байна. Энэ сард өссөн дүнгээр 131 ажлын байрны захиалга бүртгэгдэж, 120 иргэнийг ажилд зуучилсан байна. Ажилд зуучлагдсан иргэдийн 58 нь байнгын ажлын байртай болсон. Шинээр бий болсон 26 ажлын байрны мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

2021 онд хэрэгжих 5 хөтөлбөрийг 04 дүгээр сарын 25-наас иргэдэд цахимаар танилцуулсан. “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмадын

хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг 05 дугаар сарын 25-наас 06 дугаар сарын 01-ны хооронд зарлаж цахимаар нийт 97 иргэн бүртгүүлээд байна.

Аудитын газраас гаргасан дүгнэлтийн дагуу санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөө хийгээгүй сумдыг хэлтсийн дарга, хяналтын мэргэжилтэнүүдэд хариуцуулсанаар эргэн төлөлт 87 иргэний 53,436.6 мянган төгрөгийг төвлөрүүлж авлагыг бууруулж ажиллалаа.

“**Хөдөлмөрийн цахим яармаг–2021**” сургалтанд 2021-05-08 нд сууж <https://www.expo-mongolia.org/careerexpo> цахимыг Сүхбаатар аймаг цахим группд 23 удаа шэйр хийж иргэдэд хүргэсэн.

Зорилтот бүлгийн иргэдийг бүлгийн зохион байгуулалтад оруулан хүнсний ногоо тариалах арга хэмжээний хүрээнд 1 га газар хагалуулж борнойдуулсан. Бүлгийн ногоо тариалах хүсэлтэй зорилтот өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэдийг аймгаас 15 км-т тариалангийн газар тэгшлэх, төмс хатаах нарлуулах, савлах, жижиг хүлэмжид 24 ширхэг помидор суулгах зэрэг ажлууд хийлгээд байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяныг зохион байгуулсан ажлын хэсэг 05/10-ны өдөр хуралдаж зохион байгуулсан байгууллагууд тайлангаа тавьж 2021 онд ХАБЭА-н чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө гаргасан.

Сарын аяны хугацаанд зарласан “Хямралыг урьдчилан харж, бэлтгэлтэйгээр даван туулья” болзолт уралдаанд амжилттай оролцож олон нийтийн сүлжээнд сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажлыг сайн хийсэн Эрдэнэцагаан сумын ЗДТГазар, “Боловсрол-Өргөө” дотуур байр, ДБЭХС ТӨХК-ны Сүхбаатар салбар зэрэг байгууллагуудыг шалгаруулж Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнахаар ажлын хэсгээс шийдвэрлэсэн.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламж: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн хувийн хэргийг хянаж, баталгаажуулан олголт хийв.

2021 онд нийгмийн халамжийн орон нутгийн төсвөөс 115,5 сая төгрөг төгрөгийг, улсын төсвөөс 6883,6 сая төгрөг нийт 6999.1 сая төгрөгийг зарцуулагдахаар тусгагдсан байна. 2021 оны 05 дугаар сард олгох 9 иргэний 146472.6 мянган төгрөгийн тэтгэмж, 6 иргэний 650,0 мянган төгрөгийн ахмадын хөнгөлөлт, 151 иргэний 4044,4 мянган төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтийн жагсаалтыг тулган Хаан болон Төрийн банкруу илгээсэн. “E-halamj” цахим системээр олгогдох 1187 иргэний 335695.5 мянган төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний болон ахмад настны тэтгэврийн, 558 иргэний 20590,7 мянган төгрөгийн жирэмсэн эхийн тэтгэмж, 3175 иргэний 155424,2 мянган төгрөгийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, 1иргэний ихэр хүүхдийн тэтгэмжийн жагсаалтыг тулган баталгаажуулж төрийн сан илгээсэн.

И-халамж системд хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэврийн 30, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн 52, жирэмсэн эхийн 124 үйлчилгээг цахимаар хүлээн авч хянан баталгаажуулсан. Баруун-Урт сумын нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийн талаархи 51 иргэнд мэдээлэл, зөвөлгөөг цахимаар өгч, 13 иргэний үйлчилгээг “e-halamj” программд бүртгэсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн 3/301 тоот албан бичгээр хүнсний эрхийн бичиг олгох журамд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдуулан хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авагч өрхийн цахим картыг пин коджуулах ажлыг зохион байгуулж байна. Тус үйлчилгээнд хамрагдаж байгаа 1212 өрхийн иргэдийн цахим картыг пин коджуулах ажлыг 04 дүгээр сараас орон нутгийн Төрийн банкны салбар тооцооны төвтэй хамтран зохион байгуулан ажиллаж байна. Асгат, Баяндэлгэр, Дарьганга, Наран, Түвшинширээ, Халзан сумд пин коджуулалтаа 100 хувь хийж гүйцэтгэсэн. Өнөөдрийн байдлаар 1086 өрх цахим картаа пин коджуулж 90 хувьтай байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2021 оны 03 дугаар сарын 09-ны “Бүлгийн төсөл хэрэгжүүлэх” удирдамжийн

дагуу 13 сумдын мэргэжилтнүүдэд чиглэл хүргүүлж ажилласан. Ковид-19 халдвар дотоодод тархсантай холбогдуулан Олон нийтийн оролцооны бүлгийн төслийг 2021 оны 05 дугаар сарын 25-ны хүртэл хойшлуулсан.

Аймгийн улаан загалмайн хороотой хамтран зорилтот бүлгийн хүнсний талон авдаггүй, өрх толгойлсон эх/эцэг/, хөгжлийн бэрхшээлтэй өрхүүдийн судалгаа гарган аймгийн хэмжээнд 300 өрхөд 60000 төгрөгний хүнсний багц үйлчилгээ дэмжлэг 18000000 төгрөгний туслалцаа үзүүлсэн. Хөдөлмөр эрхлэлтийн нийтийг хамарсан ажилд зорилтот бүлгийн 10 иргэнийг ажиллуулж, 1 иргэнд 252000 төгрөгийн цалин хөлс олгосон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 05 сард 1 удаа хуралдаж 7 хүүхэд орж 5- хүүхдийн асаргааны хугацааг сунгаж, 2 хүүхдийн байнгын асаргааг шинээр тогтоосон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын 1 дүгээр улирлын тайланг гаргаж, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Жайка олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”, Старт-2 төсөлтэй хамтран “Салбар комиссын чиг үүрэг ба кейс хэлэлцүүлэг зохион байгуулах аргачлал”-ын талаар аймаг, дүүргүүдийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийн чадавх бэхжүүлэх цахим сургалтанд хамрагдлаа.

Сүхбаатар аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодын тэргүүн нартай 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдөр уулзалт зохион байгууллаа. Уулзалтаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн танилцуулга, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хийж цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодтой хамтран хэрэгжүүлэх ажлын талаар санал хүсэлтийг сонсож ажиллалаа.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд шинээр төрсөн 98 хүүхдийг бүртгэж, хүүхдийн мөнгөн тэтгэмж авах эрхийг үүсгэсэн. 2021 оны 05 дугаар сарын байдлаар хүүхдийн мөнгөн тэтгэмжид 23586 хүүхэд хамрагдаж байна. Засгийн газраас иргэн бүрт олгосон 300,0 мянган төгрөгөө аваагүй нийт 2635 иргэнээс 1065 иргэн мөнгөө авч, 1221 иргэний дансны мэдээллийг авч, дансгүй 190, утас холбогдохгүй 159 иргэн байна.

Дөрөв. Хууль, эрх зүйн чиглэлээр:

Хууль, эрх зүй: Хилийн 0184-р анги хилийн 0146-р ангийн Хилийн бүс тогтоох Аймгийн Засаг дарга Хил хамгаалах ерөнхий газрын дарга нарын хамтарсан Захирамжийн төслийг бэлтгэн батлуулсан.

Хос далбаа ХХК-ны Аймгийн засаг даргад гаргасан гомдлын дагуу Мөнхаан сумын Засаг даргын хууль зөрчин гаргасан захирамжийг хүчингүй болгосон захирамжийг гаргуулан хариуг хүргүүлсэн. “Төмстийн сэрвэн”-гийн постны хамгаалалтад ажилласан алба хаагчдад аймгийн Засаг даргын 2 удаагийн захирамжаар 13.0 сая төгрөгийг томилолтыг олгосон.

Улсын бүртгэлийн чиглэлээр: Тус хэлтэс 2021 оны 05 дугаар сарын байдлаар дараах бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүлсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл:

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдээ: Хүлээн авсан мэдүүлгийн тоо-392, анхны бүртгэл-39, өмчлөх эрх шилжих гэрээ-42, барьцааны гэрээ-297, бүртгэлд өөрчлөлт оруулах -2, лавлагаа хуулбар-6, нийт бичигдсэн гэрчилгээний тоо-83

Газар өмчлөх, эзэмших ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээ: Хүлээн авсан мэдүүлгийн тоо-206, анхны бүртгэл-8, өмчлөх эрх шилжих гэрээ-33, барьцааны гэрээ-146,

бүртгэлд өөрчлөлт оруулах -12, лавлагаа хуулбар-7 нийт бичигдсэн гэрчилгээний тоо-53

Хуулийн этгээдийн улсын бүртгэл: 2021 оны 05 дугаар сарын байдлаар улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээдийн тоо 5 Үүнээс ХК-0, ХХК-5, төрийн бус байгууллага-0, төрийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -0, орон нутгийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -0, Төрийн байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газар-1, нөхөрлөл-1, хоршоо-0, хадгаламж зээлийн хоршоо-0, сан-0, үйлдвэрчний эвлэлийн байгууллага-1, шашны байгууллага-0, хэвлэл мэдээллийн байгууллага-0 бүртгэгдээд байна. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн-3, татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээд-0, үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болсон улсын бүртгэлийн гэрчилгээг дахин бүртгэсэн-4, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт - 4, хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналт лавлагаа олгосон -3, хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг 2 –г тус тус бүртгэн хурааж авсан байна.

Иргэний бүртгэл: Иргэний бүртгэлийн тасаг нь 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт 145 төрөлт, гэрлэлт 26, гэрлэлт цуцлалт 1, үрчлэлт 2, эцэг тогтоолт 7, овог нэр өөрчлөлт 3, нас баралт 32, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 0, үндэсний энгийн гадаад паспорт 16, шинээр олгосон иргэний цахим үнэмлэх 115, иргэн, аж ахуй нэгжид олгосон лавлагаа 599 тус тус бүртгэгдэж олгосон байна.

Шүүхийн шинжилгээний алба: Албаны бие бүрэлдэхүүн цагдаагийн газрын шуурхай албаны бүрэлдэхүүнтэй хамтран хэргийн газрын үзлэгт 10 удаа оролцсноос хулгайн хэргийн дуудлаганд 4 удаа, зам тээврийн осл дуудлаганд 2, бусад дуудлаганд 4 удаа явж, хэргийн газрын үзлэгээр тээврийн хэрэгслийн мөр 1 ширхэг, эвдэгч багажны мөр 1 ширхэг, бусад ул мөр, эд мөрийн баримт 7 ширхэг, нийт 9 ул мөр илрүүлж, бэхжүүлэн хураан авсан байна.

Криминалистикийн шинжээч нар нь тайлангийн хугацаанд гарын мөрний 1 шинжилгээ хийж дүгнэлт гаргасан байна.

Тус албаны шинжээч эмч нар нь хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 37 удаа хийснээс хүнд 2, хөнгөн 11, гэмтлийн зэрэгт хамаарахгүй 13, гэмтлийн зэрэг тогтоогдоогүй 11 дүгнэлт гаргасан байна. Шинжээч эмч нар нь химийн 1 шинжилгээ хийж дүгнэлт гаргасан байна.

хэргийн газрын үзлэгийн 167 кадр, криминалистикийн шинжилгээний 4 кадр, нийт 171 кадр гэрэл зургийг боловруулж, гэрэл зургийн үзүүлэлт хийж мөрдөгч нарт хүлээлгэн өгсөн.

Аймгийн Цагдаагийн газар баривчлагдсан 11 хүний гарын дардасыг авч, лавлагаа авах хүсэлтийн дагуу 12 хүний гарын хээний лавлагаа мэдээллийг албаны даргын зөвшөөрлөөр олгосон.

Цагдаагийн газар: Аймгийн Шуурхай штабын “Тандалт судалгааны баг”-т тус газрын 2 алба хаагч ажиллаж, батлагдсан тохиолдлуудын ойрын хавьтал 642, дам хавьтал 799 иргэний судалгааг гарган, явсан маршрут, хаяг байршлыг тогтоон “Хариу арга хэмжээний баг”-т шилжүүлсэн ба цаашид хавьтал тогтоох ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж байна. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасан тул аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 16 дугаар хурлын шийдвэрээр “Улаан” түвшин”-нд шилжүүлсэн хугацааг 2021 оны 05 сарын 08-ны өдрийн 06:00 цаг хүртэл сунгасан.

Дээрх шийдвэрийн дагуу бүх сумдаас гарах, орох хөдөлгөөнийг хязгаарлаж, хорио цээрийн дэглэм сахиулах баталгаат 46, баталгаат бус 24, нийт 70 хяналтын постод цагдаагийн 22, бусад байгууллагын 123, нийт 145 ажилтан, алба хаагч, 69 автомашинтай үүрэг гүйцэтгэсэн. Мөн аймаг, сумдын төвийн доторх хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор 120 цэгт, цагдаагийн 43, Дотоод хэргийн их сургуулийн 19, бусад байгууллагын 350, нийт 412 ажилтан, алба хаагчид эргүүл, хяналт шалгалтын чиглэлээр хамтран ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 115 дугаар тогтоолоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тул аймгийн Онцгой комиссын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 17 дугаар хурлын шийдвэрээр “Улбар шар” түвшинд шилжүүлсэн. Уг шийдвэрийн дагуу аймаг, сумдын төвийн доторх хөдөлгөөнийг хэвийн горимд шилжүүлсэн ба харин орох, гарах хөдөлгөөний хязгаарлалт хэвээр үргэлжилж байна. Энэ хугацаанд хорио цээрийн дэглэм сахиулах баталгаат 32, баталгаат бус 13, нийт 45 хяналтын постод цагдаагийн 19, бусад байгууллагын 74, нийт 93 ажилтан, алба хаагч, 44 автомашинтай үүрэг гүйцэтгэж байна.

Аймгийн Онцгой комиссын 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 18 дугаар хурлын шийдвэрээр Улсын онцгой комиссоос батлан гаргасан журамд заасан шаардлага, шалгуур хангасан иргэдийн зорчих хөдөлгөөн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг 2021 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн нээж, спиртийн өндөр агууламж /18 градусаас дээш/ бүхий согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглосон хугацааг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл сунгасан.

Шөнийн цагаар хорио цээрийн дэглэм зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор цагдаа, онцгой, тагнуулын байгууллагаас хуваарийн дагуу шөнийн эргүүлийг тогтмол зохион байгуулж байна. Энэ хугацаанд шөнийн эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн алба хаагчид хорио цээрийн дэглэмийн үед зохих зөвшөөрөлгүйгээр хөдөлгөөнд оролцсон 6 зөрчлийг илрүүлж шийдвэрлэв.

Улсын Онцгой комиссоос тус аймагт хуваарилагдсан нийт 50503 хүн тун вакциныг Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс 4 удаагийн татан авах үеийн хамгаалалтыг 2021 оны 04 дүгээр сарын 30, 05 дугаар сарын 02, 05 дугаар сарын 07, 05 дугаар сарын 14-ний өдрүүдэд зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд гаралт ихтэй зарим төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлсэн саналын дагуу одоогоор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2021 оны А/10, А/11, А/12, А/13 дугаартай захирамжаар “Архидан согтуурахтай тэмцэх”, “Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх” дэд зөвлөлүүдийг шинээр байгуулсан.

Сонгуулийн ерөнхий хорооноос тус аймагт хуваарилагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үед ашиглагдах 72 ширхэг санал тоолох төхөөрөмж, 45363 ширхэг саналын хуудас бусад техник хэрэгслийг Улаанбаатар хотоос татан авах үеийн хамгаалалтыг Тагнуулын хэлтэстэй хамтран 2021 оны 05 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд зохион байгуулсан. Мөн сонгуулийн үеэр ашиглагдах иргэний бүртгэлийн хурууны хээ унших төхөөрөмжийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас татах авах үеийн хамгаалалтыг 2021 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс зохион байгуулж байна.

Хэрэг бүртгэлтийн шатанд шалгагдаж байгаа гэмт хэрэг үйлдсэн, яллагдагчаар татагдвал зохих хүн, хуулийн этгээд нь тодорхой хэргүүдийг шийдвэрлэх зорилгоор аймгийн прокурорын газартай хамтран 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн “Хэрэг бүртгэлтийн хэргийн шийдвэрлэлт” аяныг 3 сарын хугацаатай зохион байгуулж байна. Арга хэмжээний хүрээнд энэ сард хэрэг бүртгэлтийн 8 хэргийг шийдвэрлэв.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Хүүхдийн эрх ба аюулгүй байдал” хэсэгчилсэн арга хэмжээг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэл 2 сарын хугацаатай зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд 9 төрлийн постер, 18 төрлийн мэдээллийг цагдаагийн газрын пэйж хуудас болон аймгийн олон дагагчтай 40 фейсбүүк группт түгээн иргэдэд сурталчилж, ерөнхий

боловсролын сургуулийн 562 сурагчийг унаач хүүхдийн судалгаанд бүртгэн, 431 уяачдад мэдэгдэл зөвлөмж өгч, 15 удаа эргүүл, хяналт шалгалт зохион байгуулж, 8 иргэнд холбогдох 2 зөрчлийг илрүүлэн холбогдох хууль, журамд заасны дагуу шалгаж, шийдвэрлэсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар хэсгийн 5.1.8 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлал, Уул уурхай, хүнд үйлдвэрлэл, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын хамтран баталсан тушаал, Экологийн цагдаагийн албанаас ирүүлсэн удирдамжийн дагуу “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгуулж байна. Арга хэмжээний хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтарсан шалгалт зохион байгуулж "Дөрвөн гэгээн эрдэнэ" ХХК нь 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Сүхбаатар сумын 5 дугаар багийн нутаг “Улаан чулуут” гэх газраас зөвшөөрөлгүй 600 тонн хайрга олборлосон зөрчлийг илрүүлэн, нөхөн сэргээлтийг хийлгэж байна.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн хор уршгийг иргэд, олон нийтэд таниулах, тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Экологийн цагдаагийн албанаас ирүүлсэн удирдамжийн дагуу “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг энэ оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн аймгийн хэмжээнд зохион байгуулж байна. Арга хэмжээний хүрээнд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг бүхий 2 шторк, 2 постер, 16 зурагт хуудсыг цахим орчинд байршуулан иргэдэд түгээж, 460 ширхэг санамж, сэрэмжлүүлгийг иргэдэд тарааж, Мөнххаан, Түмэнцогт сумдын нутгаар дамжин өнгөрдөг төв зам дагуу 8 ширхэг зурагт самбарыг байршуулав. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулах “Байгалиа хамгаалъя” сэдэвт “ЭССЭ” бичлэгийн уралдааны удирдамжийг боловсруулан сумдад хүргүүлэв. Уралдааны шагналын болон тараах материал хэвлүүлэх зардлыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс гаргуулахаар шийдвэрлүүлсэн.

Экологийн цагдаагийн албаны даргын баталсан удирдамжийн дагуу хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг ахиулах зорилгоор 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн “Шийдвэрлэлт” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж байна. Арга хэмжээний хүрээнд шийдвэрлэх хэргийн графикт орсон 4 хэргийн 18 холбогдогчийн судалгааг гарган, хаяг байршлыг тогтоогоод байна. Тус газрын “Дүн шинжилгээ судалгааны баг”-ийн ээлжит хурлыг зохион байгуулж, аймгийн нутаг дэвсгэрт сүүлийн 14 хоногийн хугацаанд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, цаашид анхаарах асуудлын талаар цахим танилцуулга бэлтгэн, байгууллагын пэйж хуудсанд байршуулж, иргэд олон нийтэд сурталчлав.

Алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн сургагч багш нартай хамтран “Галт зэвсэгтэй харьцах, аюулгүй ажиллагааны дадлага, буудлага үйлдэх” сургалтыг танхимын болон дадлагын хэлбэрээр зохион явуулж, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв, "Менежер карьерийн институт" сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны чадавхыг дээшлүүлэх нь" сэдэвт цахим сургалтад эрүүлжүүлэх, саатуулах байрны дарга, эмч нарыг, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв, Хүний эрхийн үндэсний комисстой хамтран зохион байгуулсан “Цагдаагийн алба хаагчийн хөдөлмөрлөх эрхийн онцлог, судалгааны дүн” сэдэвт цахим сургалтад тасгийн дарга, ахлах байцаагч /мөрдөгч, мэргэжилтэн/ нарыг, Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвөөс зохион байгуулсан “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн харилцаа, хандлага” сэдэвт цахим сургалтад “Мэдээлэл, сурталчилгаа /PR/-ны баг”-ийн гишүүдийг, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв, Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан “Удирдлагын менежмент”,

“Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” сэдэвт цахим сургалтад тасаг, хэсгийн дарга нарыг, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас зохион байгуулсан “Microsoft Teams программ” сэдэвт цахим сургалтад холбоо мэдээллийн инженерийг тус тус хамруулсан.

Алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд тус аймгийн Баруун-Урт хотын төвд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар энэ онд баригдах цагдаагийн газрын конторын шинэ барилгын шав тавих ёслолын арга хэмжээг зуны тэргүүн сарын шинийн 3-ны билэгт сайн өдөр буюу 05 дугаар сарын 14-ны өдөр батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулав. Арга хэмжээнд аймгийн төр захиргааны болон хууль хяналтын байгууллагын дарга нар, цагдаагийн газрын алба хаагч, ахмадын төлөөлөл урилгаар оролцсон. Барилгын гүйцэтгэгчээр “ИХ МОДУН” ХХК шалгарсан ба 2021 онд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын түүхт 100 жилийн ойг угтан бүтээж буй тус цагдаагийн газрын зурагт түүхийн номонд орох материалыг батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу хариуцсан алба хаагчдаас авч нэгтгэн, стандартын дагуу эх бэлтгэлийг хийж, 2021 оны 05 дугаар сарын 23-ны өдөр “Мөнхийн үсэг” ХХК-д хүргүүлэв.

Хүн амын дунд коронавируст халдвар голомтлон тархаж буй энэ үед байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 8 бүлэг, 93 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний дагуу алба хаагчдыг халдвар авах эрсдэлийн түвшинг харгалзан “улаан”, “шар”, “ногоон” бүлэгт ангилж, албан үүргээ гүйцэтгэхдээ өөр хоорондоо хавьтал болохоос урьдчилан сэргийлж, халдвар, хамгааллын дэглэмийг чанд баримтлах зорилгоор жижүүр, харуулын ажлыг хүлээлцэх, эргүүлд гарах, буух, хэргийн газрын үзлэг хийх, гэмт хэрэг, зөрчил гаргасан иргэнээс мэдүүлэг авах зэрэг өдөр тутмын үйл ажиллагааг тусгай горимд оруулсан.

Гэмт хэрэг зөрчлийн дуудлагаар болон шүүхийн шийдвэрээр тус газрын Эрүүлжүүлэх, саатуулах байранд ирж буй иргэдээс шинжилгээ авах зорилгоор тус байрны 2 эмчийг аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран “Коронавируст /ковид-19/ халдварыг илрүүлэх “PCR” шинжилгээ авах” сургалтад хамруулав.

Цагдаагийн газрын 108 алба хаагч, 24 олон нийтийн цагдаагийн ажилтан буюу 99.2 хувь нь вакцины 2 дахь тунгаа бүрэн хийлгэсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр: Тус газрын хорихоос өөр төрлийн ялын хяналтад 2021 оны 05 дугаар сарын байдлаар торгох ялаар шийтгүүлсэн урьд оны үлдэгдэл 14 ялтны 53400000 төгрөгийн материал дээр шүүхийн шинээр 54 ялтны 51130000 төгрөгийн шийтгэх тогтоол хүлээн авч, 48 ялтны 28600000 төгрөгийн ялын биелэлтийг хангаж, 20 ялтны 75930000 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Эрх хасах ялын урьд оны 25 ялтны 11729 хоногийн үлдэгдэл дээр 11 ялтны 11443 хоногийн материал нэмэгдэж, 5 ялтны 3441 хоногийн хугацаа дуусаж, үлдэгдэл 33 ялтны ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ялын урьд оны үлдэгдэл 1 ялтны 148 цагийн материалд дээр шүүхээр шинээр ирсэн 5 ялтны 720 цагийн материал ирсэн.

Үүнээс ялын хугацаа дуусгавар болсон 3 ялтны 444 цаг, үлдэгдэл 4 ялтны 512 цагийн ялын материалд хяналт тавин ажиллаж байна.

Хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээ авагдсан урьд оны үлдэгдэл 5 этгээдийн 19764000 төгрөг материал дээр шүүхээс шинээр 7 этгээдэд холбогдох 724000 төгрөгөөс 10 этгээдийн 9059300 төгрөгийн хөрөнгө орлогын хураасан авч орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр: 05 дугаар сарын байдлаар нийт 262 гүйцэтгэх баримт бичгийн 1923043.7 мянган төгрөгийн материалд шийдвэр гүйцэтгэх

ажиллагааг явуулснаас 127 гүйцэтгэх баримт бичгийн 574420.3 мянган төгрөгийн төлбөрийг биелүүлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт 50.3 хувьтай байна.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлт

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр: Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу гүйцэтгэгч тодорсон нийт 8 бараа тоног төхөөрөмжийн ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж Засаг даргын 2020 оны 06 сарын 02-ны өдрийн А/363 дугаар захирамжийн дагуу барааг хүлээн авах ажлыг зохион байгуулахаар холбогдох хэлтэст хүлээлгэн өглөө.

2022 оны Улсын төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санал илгээсэнтэй холбогдуулан холбогдох яамдууд болон өөрийн аймгаас сонгогдсон УИХ-н гишүүдэд мэдээлэлээр хангах үйл ажиллагааг гүйцэтгэж байна.

Уул уурхайн салбарт: Аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч холбогдох хэлтсийн дарга нар “Эм Эл Цахиурт овоо” ХХК-ийн уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцаж, 2021 онд байгуулах Хамтын ажиллагааны гэрээ байгуулах уулзалт, хэлцлийг хийсэн.

ОУИТБС-ын засаглалыг сайжруулах ажлын албанаас 5 дугаар сарын 19-ны өдөр зохион байгуулсан “Орон нутгийн гэрээ байгуулж, хяналт, дүгнэх” сэдэвт цахим сургалтад аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан дэд зөвлөлийн бүрэлдэхүүн оролцсон.

Түмэнцогт сумын нутагт байрлах “Монгол жүюаньли” ХХК-тай Хамтын ажиллагааны гэрээ байгуулах талаар уулзалт хэлцлийг хийсэн.

Зам тээврийн салбарт: 2021 онд улсын төсвийн хөрөнгөөр баригдах аймгийн төвийн 5 дугаар тойргийн 5,65 км, Баруун-Урт сумын 1-р багт баригдах 3,03 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн ажлын гүйцэтгэгч “Монгол Зам Групп” ХХК-тай гэрээ байгуулж ажлыг эхлүүлээд байна.

Аймгийн төвийн 2-р тойргийн хатуу хучилттай авто замын засвар, шинэчлэлтийн ажлын батлагдсан ажлын зураг төсөв, техникийн тодорхойлолтыг аймгийн Өмчийн газарт хүргүүлэн тендер зарлагдаад байна.

2021 онд хэрэгжүүлэх авто зам, замын байгууламжийн ажлын зургийн даалгавар боловсруулан батлуулан ажиллаж байна.

Авто зам, замын байгууламжаас авто зогсоол гаргах хүсэлт ирүүлсэн 2 аж ахуй нэгжийн өргөдлийг аймгийн засаг даргын А/627 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт танилцуулан холбогдох зөвшөөрлийг олгосон.

2018 онд улсын төсвийн хөрөнгөөр Дарьганга сумын төвд баригдаж эхэлсэн 2,3 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн ажлыг энэ онд дуусган ашиглалтад оруулах, хөрөнгийг шийдвэрлүүлэх, орон нутагт хүлээлгэн өгөх талаарх холбогдох саналыг аймгийн Засаг даргаас Захиалагч байгууллага “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т хүргүүлсэн.

2021 оны 05 сарын 31-ний байдлаар аймгийн Автотээврийн төвд нийт 1695 тээврийн хэрэгсэл үзлэг, оношилгоонд хамрагдаад байна. Бичигтийн боомтоор 571,3 мян.баррел газрын тос, 152,4 мян.тн хүрэн нүүрс, 956,7 тн төмрийн хүдэр экспортолсон байна.

Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ 5 дугаар сарын 24-өөс эхэлж Баруун-Урт-УБ хот чиглэлд 208 зорчигч үйлчлүүлсэн байна.

Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын чиглэлээр: Хаягийн мэдээллийн санг хэрэглээнд нэвтрүүлсэнтэй холбогдуулан 7 дугаар багийн нутаг Нарлаг, Ахмадын гудамж хэсгийн хаягийн ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд үлдсэн 5, 6 дугаар багийн хаягийг мэдээллийн оруулах ажлыг энэ сардаа багтаан дуусгахаар ажиллаж байна.

1:1000-ны масштабтай байр зүйн зургийн “Инженерийн шугам сүлжээний давхрага”-ын өгөгдөл мэдээллийг системд хандан засварлах, баяжуулах ажлын хүрээнд өмнө оруулсан

шугам сүлжээний мэдээллийг хянах, засварлах, орхигдсон шугам сүлжээг шинээр оруулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн хэмжээнд 13 сумдын 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг MNS 6702:2017 стандартын хэлбэрт хөрвүүлэх ажлын хүрээнд бэлтгэл ажлыг ханган бүх AutoCAD-ын файлыг нэгтгэх, ялган ангилах ажлыг хийсэн.

Баруун-Урт суманд 2 газарт газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгааг хийлгүүлэх мэдэгдэл хүргүүлсний дагуу газрын мониторингийн системээр хянан баталгааны дүгнэлт хийгдэж ирээд байна.

2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон ГЗБГЗЗГ-ын даргын 2021.02.26-ны өдрийн 1/420 дугаар албан бичгийн дагуу “Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн дагуу тогтоосон газар ашиглалтын тусгай горим, дэглэм, хориглолт, хязгаарлалт бүхий хамгаалалтын бүс, зурвас газрын мэдээллийг “газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн мэдээллийн систем”-д оруулахаар төлөвлөгөө гарган ажиллаж 4 дүгээр сард 13 сумын цахилгааны шугам сүлжээн мэдээллийг ГЗБ, хот төлөвлөлтийн цахим систем рүү оруулж аймгийн хэмжээнд 720 хэмжээг оруулаад байна. Мөн 13 сумын мэдээлэл холбоо сүлжээний холбоо мэдээлэл, шилэн кабелийн хамгаалалтын зурвасыг мэдээллийн санг үүсгэн ГЗБХТөлөвлөлтийн цахим системд оруулахад бэлэн болгосон.

Аймгийн хэмжээний Монгол Улсын иргэнд 2021 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын аймгийн ИТХ-ын саналыг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулж засварлан ажиллаж байна.

Баруун-Урт сумын Газар өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой 19 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Мөн 4 дүгээр сард аймгийн Засаг даргын захирамжаар 16 иргэний эрх үүсч гэрээ, гэрчилгээ, кадастрын зургаар үйлчилж байна

Аймгийн хэмжээнд 13 сумын 2022 оны төлөвлөгөөнд цахимаар санал өгөх тухай иргэдэд цахимаар мэдээлэл хүргэн ажилласан. Мөн аймгийн хэмжээнд 4 сард ирсэн 9 саналд цахимаар хариу хүргүүлэн ажиллалаа.

2021 онд БШУ сайдын багцын хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр төлөвлөгдсөн Түвшинширээ, Баяндэлгэр сумдын нүхэн жорлонтой сургууль цэцэрлэг, дотуур байрны барилгуудын ариун цэврийн байгууламжийн ажлын зураг төслийн даалгавар боловсруулан холбогдох газруудаар баталгаажуулан харъяалах яаманд хүргүүлсэн.

Баяндэлгэр сумын 300 хүний суудалтай Соёлын төвийн барилгын ажлын зургийг хянан баталгаажуулж зураг төсөлд тусгах санал, зөвлөмжийг албан бичгээр гүйцэтгэгч байгууллагад хүргүүлэн ажилласан.

Аймгийн төрийн аудитын газраас Улсын төсвийн хөрөнгө оруулалтад хийгдэж буй шалгалтад холбогдох барилга угсралтын ажлуудын бичиг баримт, тайлан мэдээг гарган өгч хяналт шалгалт хийлгүүллээ.

Барилгын материалын, сорилт шинжилгээний лабораторит 24 шинжилгээ хийгдсэн байна. Үл эвдэх аргаар 24 шинжилгээ хийн үр дүнг боловсруулан цаг тухай бүрт нь хариуг олгон ажиллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнүүдийн цахилгаан, холбоо дохиолол, дулаан, цэвэр усны шугам сүлжээний техникийн нөхцөлийн хүсэлтүүдийг холбогдох байгууллагуудад гарган хүргүүлээд байна.

13 сумын хэмжээнд орон нутагт барилгын материал /блок, явган зам талбайн хавтан/ үйлдвэрлэж байгаа иргэн аж ахуй нэгжүүдийн судалгааг 1/131 тоот албан бичгээр нэгтгэн авч суурь мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна.

Орон нутгийн барилгын материал үйлдвэрлэгч “Бага-Өлгий” ХХК, “Дарцагт-Овоо” ХХК аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүнийг тохирлын гэрчилгээг сунгуулахад дэмжлэг үзүүлэх 1/89 зөвлөмж хүргүүлэн тогтмол заавар зөвлөмж өгч ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: Ногоон байгууламжийн талаар авч хэрэгжүүлсэн ажил: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг “Бүх нийтээр

мод тарих үндэсний өдөр” –ийг 5-р сарын 15-ны Бямба гаригт “Өрх бүр хашаандаа мод таръя” уриатай ажлыг зохион байгууллаа.

“Бүх нийтээр мод тарих” аяны хүрээнд аймгийн хэмжээнд 104 албан байгууллагын 3506 иргэд оролцож 18176 ш мод сөөгийг тарьж 133.191.600 төгрөгийг зарцуулсан байна.

Үүнээс онцлох сумд:

Баруун-Урт сум: “Бүх нийтээр мод тарих” аянаар нийт 9413 ш мод сөөг тарьсанаас Боловсролын салбарын 16 байгууллагын багш, ажилчид өөрсдийн санаачилга, хөрөнгөөр “Ногоон паспорт-Ногоон төгөл” модлог ургамлын бичил цэцэрлэгт “Боловсролын систем” үүсэж хөгжсөний 100 жилийн ойгоо угтаж 6 зүйлийн 1749 ш мод тарьж 9 багийн 262 айл өрх хашаандаа 1279 ш мод сөөгийг тарьсан байна.

Баяндэлгэр сум: “Бүх нийтээр мод тарих” өдрийг сумын хэмжээнд “Өрх бүр хашаандаа 3-5 мод таръя” уриатайгаар зохион байгуулж 1 албан байгууллага, 72 өрхийн 144-н иргэд оролцож 561 мод тарьж 1461,2 мян төг зарцуулсан. 15 ААН, албан байгууллагын 312 албан хаагч 7 төрлийн 500 гаруй суулгацыг ногоон байгууламжинд тарьж усалгаа арчилгааг хийлээ. Эрдэнэцагаан сум 1.5 га талбай бүхий газар нийт 1580 ш мод тарьж бүрэн хашаа татаж хамгаалж ажиллалаа.

Сургалт сурталчилгаа: Биологийн олон янз байдлын өдрийг олон нийтэд сурталчлах, монгол орны биологийн олон янз байдлыг хамгаалахад хүүхэд залуучуудын хувь нэмрийг оруулах, оролцоог нэмэгдүүлэх, Биологийн олон янз байдлын үнэ цэнэ, ач холбогдол, хамгаалал, зохистой ашиглах талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх зорилготой аймгийн Залуучуудын холбоотой хамтран дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:

ЭНД ШИЙДЭЛ БАЙНА НЭВТРҮҮЛЭГ: Уг нэвтрүүлэгт судлаач Б.Отгонбаяр оролцсон бөгөөд тус нэвтрүүлэг нь цахим орчинд тандалт ихтэй групп, сайт, пейж хуудас, байгууллагуудын албан ёсны веб хуудсанд байршуулж орон нутгийн ТВ-ээр нэвтрүүлсэн болно.

“Хайрлъя хамгаалья” уриалгыг өрнүүлж ажилласан бөгөөд тус чөлленжид нийт 500 гаруй хүн хамрагдлаа. 1 төрлийн видео шторкыг бэлтгэх, challenge өрнүүлж, profileframe хийлгэх, “Шийдэл байна” чөлөөт подкаст зэргийг цахим орчинд тандалт ихтэй групп, сайт, цахим хуудас, байгууллагуудын албан ёсны веб хуудсанд байршуулах, орон нутгийн ТВ-р нэвтрүүлж нийт 1971 хүн хандаад байна.

Залуус бид шийдлийн нэг хэсэг мөн цахим өдөрлөгийг зохион байгуулж ажиллав. Уг цахим өдөрлөгт нийт 25 оролцогчид цахимаар оролцсон бөгөөд танхимаар залуучуудын холбоо болоод эко клубын сурагчид нийт 40 хүн хамрагдав. Илтгэгч багшаар аймгийн судлаач нар оролцсоноороо онцлог байлаа.

Залуус бид шийдлийн нэг хэсэг чөлөөт подкастыг хийж олон нийтэд хүргэж ажиллав. Үе үеийн төлөөлөл оролцуулсан чөлөөт подкастын хандалт ихтэй сайт группт байрлуулж нийт 981 хүн үзсэн байна. Энэ өдөрт зориулж зохион байгуулсан бүх арга хэмжээ нийт 3000 гаруй хүнд хүрээд байна

Наран суманд Байгаль хамгаалах өдөр”-ийн хүрээнд ЕБС, насан туршийн боловсролын багш санаачилсан “Байгальдаа ээлтэй хандая” уриалгад төрийн албан хаагчид болон сурагчид нэгдэж сумын төвийн цэцэрлэгт хүрээлэнгийн хог хаягдал, Наранбулаг, Ширээ хавирга, Буруухавирга зэрэг булгийн хогийг цэвэрлэж одоогийн байдлаар 3 тн гаруй хог хаягдлыг цэвэрлээд байна.

БОАЖГ-ын фейсбүүк хуудсаар дамжуулан 25 удаагийн мэдээлэл оруулж 25565 иргэний хандалт авсан байна.

Алтан гэгээ ХХК-тай зүг чиг заасан 12 ш замын тэмдэг тэмдэглэгээ хийх худалдах, худалдан авах гэрээ хийж 747780 мян төгрөгөөр тэмдэглэгээг хийж гүйцэтгэсэн. 6 сарын эхээр замын тэмдэг тэмдэглэгээг Дарьганга сум явах замд суурилуулах юм.

Монголиан гайд тур ХХК-тай “Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын нөөц даацын судалгаа” хийхээр зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулаад байна. Уг ажил 5 сарын 25 наас 7 дугаар сарын 25 ны хооронд хийгдэж дуусна.

Хүрээлэн буй орчны чиглэлээр хийгдсэн ажлууд: Мөнххаан, Баяндэлгэр, Эрдэнэцагаан, Онгон, Түвшинширээ, Халзан, Наран, Сүхбаатар сумдад “Бүх нийтийн их цэвэрлэгээ”-г зохион байгуулж 111 ААНБ-ын 584 албан хаагч, 915 өрх оролцож 113 тн хог хаягдлыг цэвэрлэж зайлуулахад 1481 мян төгрөгний зардал гарсан байна.

Эрдэнэцагаан суманд хогийн нэгдсэн цэгийн 8 га талбай бүхий газарт тархаад байсан хогийг ковшаар түрж цэгцлэн 350 тн хогийг булшилж түрхэд нийт 4,5 сая төгрөгний зардал гарсан байна.

Онгон, Уулбаян сумдад малын сэг устгах халдваргүйжүүлэлт хийх ажлын хүрээнд 300 гаруй малын сэг зэмийг устгаж ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.

Онгон сумын Хавиргын булгийн эх болон ойр орчмыг цэвэрлэхэд 12 хугацаат цэргийн албан хаагч оролцож 30 орчим га талбайн 1тн хог хаягдлыг цэвэрлэлээ.

Халзан сумын Залуучуудын холбоо Сүмийн булаг, Самын булгийн орчмыг хог хаягдлыг цэвэрлэж 2,3 тн хог хаягдлыг өөрсдийн хүчээр цэвэрлэсэн байна.

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар: Эрдэнэцагаан суманд Багийн засаг дарга нартай хамтарч түймэр гарах эрсдэлтэй саруудад ард иргэдийг сонор сэрэмжтэй байлгах үүднээс хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх заавар зөвлөгөөтэй гарын авлага тарааж, гарын үсгийн баталгаа авч ажилласан. Нийт 480 ш гарын авлага тарааж, 480 өрхөөс гарын үсгийн баталгаа авч ажилласан байна. Мөн Онгон сумын 510 өрхөд 2 удаа масс мессеж мэдээ хүргэсэн байна.

Уул уурхайн чиглэлээр: Эрдэнэцагаан Уул уурхайн тээвэрлэлт хийж байгаа машинууд зам эвдэж, тоосжилт ихээр бий болгож хүн малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна гэсэн гомдлын дагуу 1-р багийн Засаг дарга Ё.Самдан тус багийн иргэдийн хамт ажлын хэсэг ажиллаж тээвэрлэлт хийж буй машинуудыг зургаар баталгаажуулж дээрх аж ахуй нэгжүүдэд албан тоот хүргүүлээд байна.

Сүхбаатар сумын нутаг болох Ганц худаг гэдэг газраас түгээмэл тархацтай ашигт малтмал хайрганы гэрээг Сүхбаатар сум Дөрвөн гэгээн ХХК-тай хийсний дагуу хяналт шалгалт хийж газрыг зааж өгч эмх цэгцтэй авуулах чиглэлээр хяналт тавьж ажиллаж байна. Дөрвөн гэгээ ХХК 2 өдөр 10 машин хайргыг авч нөхөн сэргээлтийг хийсэн.

МХЕГ-ын даргын баталсан 01\11 тоот удирдамжийн дагуу Баруун-урт суманд үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-дад агаарын бохирдуулагч эх үүсвэр, нам даралттай уурын зуухны ашиглалт хяналт шалгалт хийж албан шаардлага хүргүүлж ажилласан.

Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны чиглэлээр: ТХХЗөвлөлийн 2021 оны анхны хуралдааныг 2021.05.14-ны өдөр зохион байгуулж ажиллалалаа. Хуралдаанд ТХХЗөвлөл бүрэлдэхүүн 100 хувь оролцож, Зөвлөлийн 2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаан төлөвлөгөө, ажлын албадын бүтэц, бүрэлдэхүүнийг хурлаар хэлэлцүүлэн батлууллаа. Албадын ахлагч нарт 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг ханган ажиллах, ТХХЗөвлөлийн даргын гарын үсэг бүхий чиглэл хүргүүлж ажиллалаа.

Мөн ТХХТүншлэлийн хүрээнд 2021-2024 онд Сүхбаатар аймагт хөгжүүлэх жижиг, дунд үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийг ТХХЗөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, аймгийн Засаг даргын 2021.05.21-ний өдрийн А/308 дугаар захирамжаар баталгаажуулан олон нийтэд зарлаад байна.

Тус тэргүүлэх чиглэлийн Ноос угаах үйлдвэрлэлийг ТХХЗөвлөлийн гишүүн “Дөрвөн гэгээн эрдэнэ” ХХК нь хэрэгжүүлэх санал санаачлага гаргасан бөгөөд ХАҮТанхим, ХХААГазрын төлөөлөлтэй хамт үйлдвэрлэлийн барилгын үйл ажиллагаа, тоног төхөөрөсөлтэй танилцаж, цаашид төрийн байгууллагатай хамтран ажиллах хүрээнд аж ахуй нэгжийн удирдлагатай санал солилцлоо.

Аймгийн Засаг даргын 2021 оны 05 сарын 21 өдрийн А/307 дугаар Захирамжаар 8 аж ахуй нэгжийн согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйчлэх тусгай зөвшөөрлийг сунгасан, 1 аж ахуй нэгжид шинээр олгосон байна.

Мерит төслөөс санаачлан төсөл хэрэгжиж буй 4 аймгийн ХОХБТХ, Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн газрын албан хаагчид үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр аймаг орон нутагт хэрэгжүүлж байгаа туршлагаас хуваалцах онлайн уулзалтыг 2021 оны 05 сарын 21-ний өдөр зохион байгуулж, ажилласан. Энэ удаагийн уулзалтыг Сүхбаатар аймаг зохион байгуулсан бөгөөд тус уулзалтаар уул уурхайн компаниудын худалдан авалтад орон нутгийн бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж ажил, арга хэмжээг танилцуулж, санал солилцлоо. Уулзалтад Түмэнцогт, Уулбаян, Мөнххаан, Асгат сумдын жижиг дунд үйлдвэрлэлийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд хамрагдсан байна.

Япон улсын санхүүжилт бүхий Жайка олон улсын төслийн байгууллагаас орон нутгийн хөдөө аж ахуйн салбарын бизнесд 20,000 даллорын буцалтгүй тусламж үзүүлэх төслийн саналд Баяндэлгэр сумын “Хургандай” ХХК-ий арьс шир боловсруулах цехийн үйлдвэрлэлийн төслийг хүргүүлээд байна.

Хөдөө аж ахуй: Монгол Улсын “Хошой аварга малчин өрх”, “Улсын хошой аварга малчин өрх” цол тэмдэгээр шагнагдсан малдчин шагналыг 5 сарын 21-23-ны өдрүүдэд Зам тээврийн дэд сайд, аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нар гардуулан өгсөн.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн /нэмэлт санхүүжилт/ хөрөнгөөр Мал эмнэлгийн үйлчилгээний хашааны ажилд “Шарга”ХХК, Мөнххаан суманд өвс тэжээлийн агуулах саравч шинээр ажилд “Цахиртүмэн-Алтай”ХХК тус тус тендерт шалгарсаны дагуу гэрээ байгуулан, гэрээний үүргийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар 1,7 сая эх мал төллөхөөс 1.2 сая толгой мал төллөөд байна. Энэ нь төллөвөл зохих хээлтэгчийн 77,0 хувийг эзэлж байгаа ба гарсан төлийн 98,6 % нь бойжиж байна. Төрлөөр нь авч үзвэл:

Төллөвөл зохих ингэний 57,7%

Гүүний 48,1%

Үнээний 48.2%

Эм хонины 80,1%

Эм ямааны 78,7% нь төллөөд байна.

2021 оны 01 сараас хойш нийт 33531 толгой том мал хорогдоод байна. Үүнд: Тэмээ 22, Адуу 1321, үхэр 2803, хонь 13713, ямаа 15672 хорогдсон. Энэ нь нийт мал сүргийн 0.8 %-ийг эзэлж байна. Үүний дотор азарга 1, 8 бух, 696 хуц, 744 ухна нийт 1449 хээлтүүлэгч хорогдсон байна. Баяндэлгэр суманд хамгийн их буюу 8698, Мөнххаан суманд 6334 толгой мал хорогдсон бол Уулбаян суманд 336 малын хорогдолтой байна.

2020 оны жилийн эцсийн мал тооллогын дүнд үндэслэн дутагдаж буй хээлтүүлэгчийн тоог гарган бүх сумдад хүргүүлснээс гадна аймгийн Засаг дарга сумдын Засаг даргатай байгуулсан гэрээнд нөхөн тавих хээлтүүлэгчийн тоог сум тус бүрээр гаргаж нөхөн тавих талаар тусгасан. Аймгийн хэмжээнд буур 54, азарга 124, бух 2507, хуц 5036, ухна 3759 дутагдаж байгаагаас Халзан, Онгон сумдад 2 буур, 37 азарга, 50 бух, 76 хуц, 73 ухна нөхөн тавьсан мэдээ ирүүлээд байна.

Чанар стандартын шаардлага хангасан өсвөр хээлтүүлэгч бойжуулах, нас гүйцсэн хээлтүүлэгч нийлүүлэх талаар захиалгыг Баяндэлгэр, Эрдэнэцагаан, Түмэнцогт сумдаас авч Малын удмын сан үндэсний төвд хүргүүлсэн.

2020 оны ноосны урамшуулалд нэр, данс зөрүүтэй 640 иргэний мэдээллийг шалгаж, залруулга хийж ХХААХҮЯ-нд хүргүүлсэн. 137 малчин өрхийн дансны дугаарыг сумдаас авч нэгтгэн яамны СХО газарт хүргүүлсэн.

ХХААХҮЯ-наас олгосон нарийн ногооны үрийг татан авч сумдад болон иргэдэд олгож байна.

Ажлын байр дэмжих зээлийн хүрээнд арилжааны банкуудад давхардсан тоогоор 649 иргэн, аж ахуй нэгжээс 49.1 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт ирүүлсэн байна. Үүнээс 296 иргэн аж ахуйн нэгжид 15077.0 зээлийг олгосон байна. Одоогийн байдлаар банкуудад 255 иргэн, аж ахуй нэгжийн 20.1 тэрбум төгрөгийн зээл судлагдаж байна.

Газар тариалангийн ажил эхэлсэнтэй холбогдуулан Сүхбаатар, Мөнххаан, Уулбаян, Баруун-Урт сумдад нийт 18 га талбайд техник дундын үйлчилгээг хийж үзүүлээ.

Мал эмнэлэг: Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/100 тоот тушаалаар томилогдсон мэргэжлийн 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2 хоног ажиллаж, аймгийн МЭГ-ын хийж хэрэгжүүлж буй ажилтай танилцан, ХХААХҮЯ-ны сайдын 01 тоот албан даалгаврын хэрэгжилт, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, цахим системийн гүйцэтгэл, малын шилжилт хөдөлгөөн зэргийг баримтаар тулган, мал эмнэлгийн газар, тасгийн мэргэжилтнүүдэд цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар үүрэг чиглэл, МЭЛ-ийн эмч нарт оношлогоо шинжилгээний арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Мал амьтны эрүүл мэндийн албанаас Онгон, Баяндэлгэр, Халзан сумдын хил залгаа нутагт шүлхий өвчин оношлогдсонтой холбогдуулан дээрх сумдын өвчлөмтгий нийт мал сүргийн судалгааг гаргаж шаардагдах вакцины хүсэлтийг Мал эмнэлгийн ерөнхий газарт хүргүүлсний дагуу Хэнтий аймгийн мал эмнэлгийн газрын хөргүүрт хадгалагдаж буй 550 мл /мян вакциныг татан авч дээрх сумдад хуваарилан дархлаажуулалтын ажил хийгдэж байна.

Мөн гоц халдварт өвчин оношлогдсонтой холбогдуулан Мал эмнэлгийн газрын гоц халдварт өвчинтэй тэмцэх халдвар хамгаалалын нөөцийг бүрдүүлэх зорилгоор 2021.05.17 өдрийн 1/60 тоот хүсэлтийг Мал эмнэлгийн ерөнхий газарт хүргүүлээд байна.

Уулбаян, Дарьганга сумдаас ирсэн дээжинд шөвөг яр өвчин оношлогдсон тул сумдын тасаг, хувийн мал эмнэлгийн нэгжид дээрх өвчинтэй тэмцэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар заавар зөвлөмжийг өгсөн.

Уулбаян сумын мал эмнэлгийн тасгаас хүсэлт ирсний дагуу МАЭМалбанаас ажлын хэсэг гарч өвчлөл гарсан хот айлд очиж мал сүрэгт эрүүл мэндийн үзлэг хийж урьдчилсан онош тогтоож баталгаажуулах шинжилгээнд дээж авч ажиллаа.

Баянхонгор аймгийн Гучин ус сумаас отор нүүдэл шилжилт хөдөлгөөнөөр орж ирсэн 4 хот айлын мал сүрэгт эрүүл мэндийн үзлэг хийх, мал амьтны эрүүл мэндийн дэвтрийн хөтлөлт, хэрэгжилт хяналт тавьж, мал сүргээ мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээнд хамруулах талаар зөвлөмж чиглэл өгч ажиллаа.

5 сард гоц халдварт өвчний дуудлага 5, халдварт өвчний дуудлага 2, халдваргүй өвчний дуудлага 8 удаа ирснийг мал эмнэлгийн газар, мал эмнэлгийн тасаг, хувийн хэвшлийн эмч нар газар дээр нь очиж үзлэг тандалт хийх, эмчлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч ажиллаа.

Мал эмнэлгийн нэгдсэн системийг мал эмнэлгийн салбарт хэрэгжүүлж сүүлийн 5 сарын байдлаар отор нүүдэл, шилжилт хөдөлгөөн, үржлийн зориулалтаар 3683 гэрчилгээ бичигдэж хянан баталгаажуулалт хийгдэн хүнсэнд зориулалтаар 912 гэрчилгээ олгогдсон байна.

Халзан, Баяндэлгэр, Онгон суманд шүлхий вакцин 50% -тай таригдаж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 02 тоот албан даалгавар, Мал эмнэлгийн газрын даргын 2021.03.03 А/06 тоот тушаал, 2021.05.19 1/65 тоот зөвлөмж, ажлын удирдамжийг гаргаж сумдад хүргүүлэн, отор нүүдэл, мал амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж зориулалтын устгалын цэгт хийж халдваргүйтгэлийн арга хэмжээ зохион байгуулан ажиллаж байна.

05 дугаар сарын 25-ны байдлаар: Орон нутагт зүй бусаар хорогдсон тэмээ-23, адуу-1314, үхэр- 2759, хонь-13640, ямаа- 15491 нийт- 33277 толгой мал бүртгэгдснээс мал амьтны сэг зэмийн устгалд: тэмээ-16, адуу-883, үхэр-1636, хонь-6140, ямаа-6165, бусад амьтны-928 нийт- 15768 ш сэг зэмийг цуглуулан устгалын нэгдсэн цэгт төвлөрлүүлэн халдваргүйтгэлийг

хийж, эрүүлжсэн бүс нутгийг сумдын Байгаль орчны байцаагч нарт хүлээлгэн өгч ажилласан.

Дээрх арга хэмжээний дагуу: малын хашаа хороо-876 ш 1051.5м², өтөг бууц-264ш 316,8 м², худаг уст цэг-166 ш 199.7 м², бэлчээрийн талбай-986.4м², агуулах зоорь түүхий эд-102 ш 78.9 м², устгалын цэгийн талбай-158,7 м², устгалын цэгийн тоо-44 нийт -2.775,0 м² талбайд халдваргүйтгэлийг хийж ажиллаа.

Итгэмжлэлийн үл тохиролын залруулгыг хийж САЗ боловсруулсан. Итгэмжлэлийн хүрээнд Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний лабораторийн менежментийн тогтолцоо сургалтанд цахимаар оролцсон.

Нийтийн эрүүл мэндийг хамгаалах, орчны эрүүл ахуйг сайжруулах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2021 оны 03-р сарын 28-наас эхлэн 13 сумын мал эмнэлгийн тасаг, хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүд халдваргүйтгэлийг үе шаттайгаар хийж байна. Халдваргүйтгэлийн ажилд хамтран ажиллаж байгаа 9 байгууллага, хяналтын пост 35, шуурхай штабт ажиллаж байгаа хүний тоо 38, хөдөлгөөнт тээврийн хэрэгслийн 42, халдваргүйтгэлийн ажилд ажилласан тээврийн хэрэгсэл 30 ажиллаж байна.

Халдваргүйтгэлд 65 ААНэгж байгууллага, орон сууц, оффисын байр 242,8 талбайд, 1150 нийтийн эзэмшлийн талбай 1,5 сая м.кв, Мал, мах бэлтгэлийн 30 цэгт, 110,7 м.кв, 55 агуулах 143,4 м.кв, бохирын цооног, гэр хороололын муу усны нүх, жорлон 1315 ширхэг, 89,0 м.кв, бусад талбай 329,7 м.кв нийт 2,4сая м.кв талбайд халдваргүйтгэлийг хийж гүйцэтгээд байна. Үүнд: Эмийн бодис сукеркилл 173 кг, Хай коф 125 кг, Роксицид 55кг, Жавелион 2710 ширхэг, ХХХувцас 150 ш, Нүдний шил 150 ш, Маск 150ш, бээлий 120 ширхэг зарцуулагдсан байна.

Эрчим хүчний чиглэлээр хийсэн ажлын тайлан: Асгат сумын 35кВ, Талбулагийн 10кВ-ын ЦДАШ-д төлөвлөгөөт засварын ажил хийгдсэн.

Баруун-Урт сумын 10/0.4кВ-ын дэд станцуудын тоноглолд цэвэрлэгээ чангалгаа, газардуулгын хэмжилт, Асгат, Эрдэнэцагаан сумын 35/10кВ-ын ХБ-ын тоноглолд цэвэрлэгээ чангалгаа РХ-ын туршилт, Баруун-Урт 0.4кВ-ын 61 шитэнд хамгаалалтын хоолой, газардуулга, битүүмжлэл сайжруулах ажил хийгдсэн. 5. 10/0.4кВ-ын 6 дэд станцад хамгаалалтын хашаа хийгдсэн.

Зургаа. Батлан хамгаалах салбарт

Батлах хамгаалахын төв архив, Тагнуулын ерөнхий газрын тусгай архив, Хил хамгаалах ерөнхий газрын хилийн цэргийн төв архивуудад цэргийн алба хаасан тухай архивын лавлагааг хүссэн 9 иргэний хүсэлтийг албан бичгээр гаргуулан олгосон.

Сүхбаатар аймгаас 2020 оны нэгдүгээр ээлжээр татагдан Хилийн цэргийн 0132 дугаар ангид хугацаат цэргийн алба хаасан түрүүч, байлдагч нар 2021 оны 05 дугаар сарын 09-ны өдөр халагдан ирж цэрэг халагдан ирсэн. Халагдан ирсэн цэрэг дайчдаас түргэвчилсэн шинжилгээ авч вакцинжуулалт хийгдсэн.

Долоо. Сумдад зохион байгуулагдсан ажил

Асгат:

Бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулан 5 аж ахуйн нэгж, 10 айл өрх 161 хүн хамрагдаж 6 төрлийн 801 модыг тарьж суулган усалгаа хийж ажиллалаа.

2021.05.24ний байдлаар 316 хүнээс коронавирусын халдварыг илрүүлэх түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийхэд 212 сөрөг, 4 сул эерэг тохиолдол гарсан. гарсан. Уг тохиолдлыг Дорнод аймгийн БОЭТ-д PCR шинжилгээнд хүргэсэн. Сөрөг гарсан.

Тус сумын хэмжээнд давхардсан тоогоор 207 иргэнийг гэрийн ажиглалтанд авсан. Гэрийн ажиглалтанд 7 хоносны дараа хүн бүрийг түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийн сөрөг гарсан тохиолдолд зөвөлгөө өгч, гэрийн ажиглалтаас гаргаж байна.

2021.05.24ний байдлаар вакцины хамрагдалт

- 18-49 нас-912

- 50-54 нас-136
- 55-59 нас-123
- 60-64 нас-116
- 65-с дээш-99 нийт 1502 1-р тунд, 399 хүн 2р тунд вакцинд хамрагдсан
Засгийн газраас иргэн бүрд олгож байгаа 300,0 төгрөгийн олгогдоогүй 105 иргэний нэрсийн жагсаалт ирж хаан, болон төрийн банканд тулгалт хийснээс 96 иргэн данстай 9 иргэн дансгүй байсныг иргэдтэй холбогдож 8 иргэн данс нээлгэж 1 иргэн дансгүй байна.

Баруун-урт:

2021 оны хаврын тариалалт эхлээд байгаа бөгөөд 0,1 га талбайд 5 нэр төрлийн хүнсний ногоог 6 иргэн тариалсан. Сумын хэмжээнд 15 аж ахуй нэгж, 51 иргэн төмс 20.2 га, бусад хүнсний ногоог 15.1 га-д тариалаад байна.

Тамхины болон үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн 13 аж ахуй нэгжид зөвшөөрөл олгосон.

Аймгийн Засаг даргын А/263 дугаар захирамж болон МХЕГазрын даргын 01/05 тоот удирдамжийн хүрээнд Баруун-Урт суманд худалдаа, үйлдвэр, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 93 аж ахуй нэгж, иргэн хамруулан УОК-ын даргын түр журмын хэрэгжилтэд ажлын хэсэг 2021 оны 05 дугаар сарын 08-20-ны өдрүүдэд хяналт хийж ажиллалаа. Тухайн худалдаа үйлчилгээний газруудад УОК-ын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 41 тоот тушаалаар баталсан түр журмын танилцуулж, баталгаажуулан, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөн цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол зохион байгуулж, амны хаалтгүй иргэнд үйлчлэхгүй байх, үйлчлүүлэгчийн биеийн халууныг хэмжин бүртгэл хөтлөх, хүн хоорондын зайг бариулах, тэмдэг тэмдэглэгээг сэргээн ажиллах талаар зөвлөгөө, зөвлөмж өгч улсын байцаагчийн шалгалтын тэмдэглэлээр үүрэгжүүлэн, мөн Гамшгаас хамгаалах хяналтын улсын хяналтын улсын байцаагч томоохон худалдааны төвүүдэд мэдэгдэл хүргүүлэн биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Ногоон байгууламж, дэд бүтэц, хог хаягдлын чиглэлээр: Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Шаргын модод ХХК нь ОНХС-н хөрөнгөөр 12.5 сая төгрөгийн өртөгөөр Боловсрол хороололд 400м, Нарлаг хороололд 300 м газарт нийт 2100 ш модыг шинээр тарьсан.

“Ойжуулалт хайлааст” ХХК – нь 7.2 сая төгрөгийн өртөгтэй 1400 ш мод, 40 кг зүлэгний үр нийлүүлэх ажлыг 100% гүйцэтгэсэн. “Ойжуулалт хайлааст” ХХК – нь 9.9 сая төгрөгийн өртөгтэй 1937 м 2 зүлэгжүүлэх ажлыг 3 хэсэг газарт 4-н замын урд хэсэгт 700м2, 36а баруун тал, 500м 2, Одконы баруун тал 600м 2 талбайг тэгшилж бор шороог дэвсэж бэлтгэл бэлэн байдлыг хангаж байна.

Нийтийн эзэмшлийн зам дагуу 4 хэсэг газарт 1200 ш модыг шинээр тарьсан.

2021 оны хаврын тарилтын мэдээгээр 11501 модыг шинээр тарьж 99,0 сая.төгрөгийн зардал гаргасан байна.

5-р тойргийн модыг хамгаалах зурвас байгуулах ажилд Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас 50,0 сая.төгрөг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 10.0 сая.төгрөгийг шийдвэрлүүлж 5.8 км хамгаалах материалыг худалдан авсан.

Японы засгийн газрын Ядуурлыг бууруулах сангаас хэрэгжүүлж буй “хатуу хог хаягдлын цэгийг янзлах, дахивар хог авах” төслийн баг 05-р сарын 25-28-ны өдрүүдэд ажиллаж төслийн бэлтгэл ажил хийгдэж байна.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлж ажилгүй 10 иргэнийг түр ажлын байраар хангаж ажилласан.

Нохой устгалын ажлыг “Сүхбаатар тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГазар гүйцэтгэж байна. Энэ сард 30 золбин нохой устгасан байна.

Шарилжгүй Баруун-Урт аяны хүрээнд ОНХС-н хөрөнгөөр 15.0 сая.төгрөгийг тусган Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлэхээр захирамж гаргаж, гэрээ

байгуулаад байна.

Элс хайргыг зөвшөөрөлгүй авах талаар экологийн цагдаагийн албатай хамтран хяналт тавьж 2 зөрчлийг харъяалалын дагуу шилжүүлсэн. Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хуулийн дагуу Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргаа”-наас ус бохирдуулагч 46 ААНБ-н хаягдал усны дүгнэлтийг гаргаж ирүүлсэн.

5,7-р багийн үерийн далангийн хамгаалалтын засварын ажлыг хийж байна.

27 б,в, 36,38-н айлын дээвэр засварын тендерийн техникийн тодорхойлолтыг боловсруулж тендер зарлах ажил бэлэн болсон. 7-р багийн орц засварын ажлын хөрөнгө 15.0 сая.төгрөг Уртын гэгээ ОНӨААТҮГ-т шилжүүлсэн. .

Гудамж талбайн нэрэмжит хаягжуулалтын ажлыг Сумын ИТХТ-н хуралдаанаар хэлэлцэж 1-р багийн нутаг дэвсгэр Мандал хорооллын хойд их буутай хөшөөг “Соёмбот цэцэрлэгт хүрээлэн” болгосон.

Боловсрол, соёл, гэр бүл хүүхдийн чиглэлээр: Сумын хамтарсан багийн хурлыг 2 удаа хуралдуулж 3 кейс хаалаа.

Баяндэлгэр:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлыг хуралдуулан төрийн дээд шагналаар шагнагдах 13 иргэний материалыг хэлэлцэн холбогдох газарт хүргүүлэв. Сумын ИТХ ын төлөөлөгчдийн дунд цахимаар сургалт зохион байгууллаа.

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр: Бүх нийтийн мод тарих өдрийг зохион байгуулж 7 төрлийн 500 гаруй суулгацыг ногоон байгууламжинд тарьж усалгаа арчилгааг хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д бүртгэлтэй ажил хайгч 2021 оны 05-р сард хөдөлмөрийн насны ажилгүй иргэн ажил хайгчаар 1 иргэн, 6 иргэн ажилд орсныг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

2014-2020 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарлагдсан төсөл хөтөлбөрт хамрагдсан 1 иргэний 3300,0 төгрөг, хугацаа хэтрэлттэй 2 иргэнд мэдэгдлийг хүргүүлж өдөр тутсаар нь холбогдож ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн хүрээнд нийт 2 төсөл хүлээн авсан. Нийтийг хамарсан ажлын хүрээнд ЗДТГазраас ногоон байгууламж нэмэгдүүлэх төслүүдийг ХХҮГазарт хүргүүлсэн.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 58 өрхийн 282 иргэн хамрагдаж байгаа ба 05-р сарын 3,384,000 төгрөгийн "Хүнсний бүтээгдэхүүн худалдан авсан. Бүртгэл",-ийг гэрээт дэлгүүрт бэлтгэн өгч өрхүүдэд олгуулж байна. Хүнсний эрхийн бичгийн 5 сарын олголтын мэдээг өдөр бүрийн 15 цагт мэргэжилтэнд мэдээллэж ажилласан.

03-р сард Нийгмийн халамжийн ehalami.mn системид цалинтай ээж хөтөлбөрийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсаны тэтгэмжид 16 иргэнд-1085400₮, Жирэмсэн эхийн тэтгэмжид 9 иргэнд 360000 төгрөг нийт 33 иргэний мэдээллийг бүртгэсэн.

Ерөнхий боловсролын сургууль: Тус хичээлийн жилд 1-5 ангийг 549 сурагч, 6-12 ангид 528 нийт 1077 сурагч суралцсан. Үүнээс 9-р анги 64 дүйцсэн хөтөлбөрөөр 3 сурагч нийт 67, 12-р ангийг 82 сурагч суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшиж төгслөө.

05 сарын 17-ноос 06 сарын 17 хүртлэх хугацаанд матетатик, монгол хэл, нийгэм, түүх, орос хэл, газарзүй, хими, биологи, англи хэл зэрэг хичээлүүдээр 62 сурагч элсэлтийн ерөнхий шалгалтын давтлагад хамрагдаж байна.

“Бүх нийтийн мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан Боловсролын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн бүтээлч ажил болгон ЕБС-ийн хамт олны зүгээс нийтийн эзэмшлийн талбайд 150 ширхэг мод тарьж усалгаа хаягжуулалт хийлээ. Мөн өөрийн эзэмшлийн газрын 100 модыг арчлан сэргээж, өмчлөлийн газартаа орчны цэвэрлэгээ хийв.

Өсвөр насны хүүхдүүдийг байгаль дэлхийдээ хайртай, ногоон иргэн болгон төлөвшүүлэх зорилтын хүрээнд мод тарих үйл ажиллагаанд Б.Ариунжаргал багштай 106 анги болон 10-12 дугаар ангийн сурагчид өөрсдийн санаачигаараа 24 ширхэг мод суулгасан.

Эрүүл мэндийн төв: Ковид-19 халдварын түргэвчилсэн шинжилгээг 175 иргэнд хийж 1 эерэг гарсанг АНЭ-т баталгаажуулах PCR шинжилгээнд явуулсан. Голомтын эцсийн ариутгал 288мкв талбайд хийсэн. Голомтод бүс нутгаар зорчин ирсэн иргэдийг гэрийн ажиглалтын хугацаа дууссан өдөр ковид-19 халдварын түргэвчилсэн шинжилгээ хийн ажиллаж байна.

Ковид-19 халдварас урьдчилан сэргийлэх Хятад улсын Синофарм үйлдвэрийн Вероцелл вакцины 2 дахь тунг ЭМТ-ийн эмч, ажилчид ЕБС, Бөмбөөлэй хүүхдийн цэцэрлэгийн багш ажилчид, Сумын онцгой комисс, Мал эмнэлэг, Цагдаа, Эрчим хүчний 180 хүнийг бүрэн хамруулсан. 18-с дээш насны 3257 иргэнээс 3101 иргэнийг вакцины 1 тунд хамруулж 95%-тай байна. 2 дахь тунгийн вакцинжуулалт одоо үргэлжлэн явагдаж байна.

Цэцэрлэг: “Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт хяналт шинжилгээ үнэлгээ” цахим сургалтанд - 23 багш, Жендерийн сургалтанд - 20 багш, Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад-1, “Төсөлд суурилсан сургалтын арга зүй” сургалтад - 12 багш, Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн уулзалтанд- 1, Төсөлт үйл ажиллагааны хэлэлцүүлэгт-11 албан хаагч, Мэдээлэл харилцаа холбоо технологийн нээлттэй боломжуудыг цахим хосолсон сургалтанд хэрэглэх аргууд сургалтад-20 хамрагдаж энэ сард нийт давхардсан тоогоор 88 албан хаагч цахим сургалтад хамрагдсан байна.

Бэлтгэл бүлгийн хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдалд дэмжлэг үзүүлэх 7 цуврал ном, багшийн илгээх захидалын хамт өдрийн бүлгийн 100 хүүхдэд бүрэн хүргэж дууссан. Ингэснээр хүүхдүүд цахимаар үзсэн хичээлээ бататган хэвлэмэл материалаар тараасан нь эцэг эхчүүд хүүхдүүдтэй хамтран ажиллах илүү боломжтой болсон.

БШУ-ны сайдын 2021 оны А/165 тоот тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүүхдийн хувцас, хичээлийн хэрэглэгдэхүүнийг тарааж өгөх ажлыг зохион байгуулж одоогоор 95 хувьтай хүргэсэн байна.

Соёлын төв: “Сүлд” телевизээс зохион байгуулсан ардын болон зохиолын дууны цахим уралдаанд 5 уран сайханч, аймгийн ахмадын хорооноос зохион байгуулсан дуу шүлгийн цахим уралдаанд 20 ахмадыг бэлтгэн оролцууллаа.

Хорио цээрийн дэглэмийн үед номын сангийн үйлчилгээг ард иргэдэд цахимаар хүргэхэд анхаарч 2 тууж 9 өгүүллэгийг цувралаар оруулж уншигчиддаа хүргэлээ. Элсэлтийн шалгалтанд бэлтгэж буй багш сурагчид, оюутнууд гэх мэт зайлшгүй шаардлагатай уншигчдад гэрээр ном олгож үйлчилж байна

Байгаль орчин: Сумын Засаг даргын 2021 оны А/54 тоот захирамжийн дагуу Бүх нийтийн их цэвэрлэгээг сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд 2021 оны 05 дугаар сарын 08-15-ны өдрүүдэд зохион байгууллаа. Цэвэрлэгээнд 11 албан байгууллагын 280 гаруй албан хаагч, 320 гаруй айл өрх, 28 аж ахуй нэгж байгууллага цэвэрлэгээнд удирдамж хуваарийн дагуу хамрагдсан болно.

Ерөнхийлөгчийн 63 тоот зарлигийн дагуу бүх нийтийн мод тарих өдрийн хүрээнд Сумын засаг даргын 2021 оны 05 сарын 04 ны өдрийн А/55 тоот захирамжийн дагуу ИТХ, ЗДТГазар, ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Соёлын төв, 086-р тусгай рот, УЦУОШС, Эргэлтийн эмийн сан, НИК- ШТС, МТ-ШТС, Байшинт ойл ШТС, Хаан банк, Төрийн банк, Дархан бадрах өргөө ХХК, Оргих мини маркет, Мал эмнэлэг үржлийн нэгжүүд зэрэг нийт 15-н аж ахуй нэгж албан байгууллагын 312 албан хаагч 7 төрлийн 500 гаруй суулгацыг ногоон байгууламжинд тарьж усалгаа арчилгааг хийлээ.

Аймгийн засаг даргын хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх албан даалгаврын биелэлтийг хангах хүрээнд ажлын хэсэг байгуулан төлөвлөгөө гаргаж, хаваршилтын үед гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээ мэдээллийн 12 шторкыг цахим гурппүүдэд түгээн ажиллалаа.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2021 оны "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" А/262 тоот захирамжийн дагуу 2021 оны 05 дугаар сарын 09 ны өдөр Цагдаагийн тасагтай хамтран 3 караоке, 9 хүнсний дэлгүүрийн дарга, эрхлэгч нарт захирамжийг танилцуулж, спиртийн агууламж 18 градусуаас доош согтууруулах ундааг худалдах, 08⁰⁰- 20⁰⁰ хооронд ажиллах талаар зөвлөгөө өгсөн.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 5,4 сая төгрөг, 4 иргэнд 25,0 сая төгрөгийн зээлийг талх, нарийн боов, бууз, банш, суран эдлэл чиглэлээр олгосон.

2019, 2020 оны ноосны урамшуулал орж байгаатай холбогдуулан 2019 оны нэр, дансны зөрчилтэй 40 иргэн, 2020 оны 32 иргэний зөрчлийг залруулан аймгийн ХХААГазарт хүргүүлсэн.

Мал эмнэлэгийн чиглэлээр : Халзан сумын 4 дүгээр багийн малчин Б.Алтанзулын үхэрт шүлхий өвчний шинж тэмдэг батлагдаж голомтын бүсэд орсон тус сумын 5 дугаар багийн малчин Ж.Цэндсүрэнгийн үхэрт шүлхий өвчний шинж тэмдэг илэрсэнтэй холбогдуулан "Зүүн булаг" гэдэг газарт 10 км –ийн радиуст Сумын засаг даргын захирамжаар 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хязгаарлалтын дэглэм тогтоогоод байна.

Сумын засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/64 тоот "Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын вакцинжуулалт хийх тухай" захирамжийн дагуу вакцинжуулалтанд ажиллах багийн удирдах ажилтан, малын эмч, техникч, туслах ажилтан нарыг оролцуулан ажлын хэсгийг томилон 7 групп 27 хүний бүрэлдэхүүнтэй 6 багийн үхэрт, 5 дугаар багийн хонь ямаа, хил залгаа 3,4 дүгээр багийн хонь ямааны 30%-ийг вакцинжуулахаар төлөвлөөд байгаагаас 2021 оны 05 дугаар сарын 24-ний байдлаар хамрагдвал зохих 184609 малаас 90149 мал хамрагдаж 49%-ийн явцтай байна.

Дарьганга:

Төрийн удирдлагын чиглэлээр: Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, сумын Цагдаагийн хэсэг, ЕБС- хамтран "Байгалиа хамгаалъя" 200000 /хоёр зуун мянган/ төгрөгийн шагналын сантай эссэ бичлэгийн уралдааныг зарлаж 4 байрыг шалгаруулан дүгнэлээ.

Сумын Засаг даргын 2021.05.07-ны өдрийн А/65 дугаар захирамжаар "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх үед авах арга хэмжээний тухай" шийдвэрлээд, хяналт тавин ажиллаж байна. Үүнд : Төв пост 1, хөдөлгөөнт 4, нийт 5 постод хуваарийн дагуу 24 төрийн албан хаагч, Шуурхай штабын жижүүрээр 14, гэрийн ажиглалт хийх 14, ерөнхий эргүүл 7, үйлчилгээний цэгүүдэд хяналт тавих 16, бүгд 75 албан хаагч ажиллаж байгаа.

Аймаг, сумын Онцгой комиссын хурлыг 2 удаа цахимаар зохион байгуулж, үүрэг чиглэл өгсний дагуу "ГЭРИЙН АЖИГЛАЛТ"-ыг тусгайлан 4 дүгээр багийн Засаг даргаар ахлуулан хариуцуулж, баг томилсон бөгөөд өдөр бүр мэдээг тогтмол цагт өгч, хяналт хариуцлагаа чангатган ажиллаж байгаа.

2021.05.18 нд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл ажиллагааны хүрээнд сонгогчдын нэрсийн жагсаалтыг сумын 4 хэсгийн хороонд хүлээн авч, энэ өдрөөс эхлэн итгэмжлэгдсэн ажилтан болон хэсгүүдийн хариуцлагатай жижүүрүүд хуваарийн дагуу ажиллаж эхэлсэн.

2021.05.20 ны өдөр Улаанбаатар хотын "Хүний эрх –хөгжил төв" ТББ-тай хамтран Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөх үйл ажиллагааг цахимаар зохион байгуулж 34 иргэнд саналын талаар мэдээлэл өгч ажиллалаа.

Сургалт сурталчилгааны чиглэлээр: УИХ-ын Тамгын газар, аймаг сумын ИТХ-аас хамтран зохион байгуулсан "Иргэдийн төлөөлөгчдийг чадавхжуулах" цахим сургалтад сумын Иргэдийн төлөөлөгчид 100% ийн ирцтэй оролцсон.

Хувь хүний хөгжлийн чиглэлээр зохон байгуулагдсан "ХАМТДАА УРАГШИЛЪЯ" -21 чөлөнж сургалтад 5 байгууллагын 15 албан хаагч бүртгүүлэн хамрагдаж байгаа бөгөөд

бусадтайгаа хуваалцан суралцаж нийтдээ 20 гаруй албан хаагч “Хувь хүний хөгжил”-ийн төлөвлөлт, үр бүтээмжийн талаар сонирхолтой хичээлийг судалж байна.

“Амьдрал туулсан ахмадын зөвлөмж” сэдвийн хүрээнд сумын Ахмадын хорооны тэргүүлэгч 3 гишүүн, ЗДТГ-ын хууль эрх зүйн мэргэжилтэн, Нийгмийн бодлогын мэргэжилтэн нар хамтран хөдөөгийн багт 1 өдөр ажиллаж, цаг үеийн мэдээлэл, бэлчээр чөлөөлөлт, хүн малын халдварт өвчин, угийн бичиг хөтлөлт, цус ойртолтын уршиг, татвар төлөлт, архины хор уршиг, сумын хамтарсан багийн үйл ажиллагаа зэрэг сэдвийн хүрээнд сурталчилгаа хийж 9 өрхийн 24 иргэнийг оролцууллаа.

Авлигатай тэмцэх газраас бэлтгэн зохион байгуулсан цахим сургалт сурталчилгааны чиглэлээр дотооддоо **“Ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн бодлого бодох аргачлал”-аар presentation** бэлтгэж 7 байгууллагын цахим группэд байршуулж сурталчилгаа хийсэн.

Канад сангийн төсөл бичих аргачлалын цахим сургалтад ЗДТГ, ЕБС-ийн холбогдох албан тушаалтан оролцож, одоогоор ЕБС-ийн нэг, “Залуусын нэгдэл”-ТББ-ийн нэг, нийт 2 төслийг бичиж хүргүүлээд байна.

Монголын Чанарын удирдлагын зөвлөхүүдийн холбооноос цахимаар зохион байгуулсан **“Хямралын дараах бизнесийн стратеги”** 3 илтгэлт сургалтад сумын ЗДТГ-ын жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, хууль эрх зүйн мэргэжилтэн нар оролцож мэдээлэл авлаа.

Сургууль, цэцэрлэгийн талаар:

1.Сумын Цэцэрлэгийн хамт олон 5 р сард дараахь бүтээлч ажлыг хийсэн.



Монгол бичгийг албан хэрэглээнд нэвтрүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол улсын ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын “Монгол бичиг үндэсний хөтөлбөр-3”-ыг хэрэгжүүлэх хүрээнд албан байгууллага хамт олноороо 100%-тай суралцаж байна.

Теле хичээлийн үзэлт 170-124 хүүхэд хамрагдсан нь нийт хүүхдийн 72% хувийг эзлэж байна. 6 бүлгийн хүүхдүүдэд даалгавар бэлтгэн нийт хүүхдийн 75 % -д нь бүлгийн багш, туслах багш нар хамтран даалгаварыг тараагдаад байна. Бэлтгэл бүлгийн хүүхдүүдийг сургуульд бэлтгэх бэлэн байдлыг хангах зориолготой 8 дасгал даалгаврыг мэргэжлийн бүлгийн багтай хамтран боловсруулж, эхний 2 ээлжийн даалгаварыг бэлтгэл бүлгийн 62 хүүхдэд 100% хүргүүлсэн. Дараагийн даалгаварыг тараах үед өмнө өгсөн даалгавараа буцааж хураан авч үр дүнг тооцон ажиллаж байна.

Сургууль: Сүхбаатар аймгийн ХГБЗХГ-аас зохион байгуулагдаж буй “ОРОЛЦООД ХӨГЖЬЕ” хүүхдийн чуулга уулзалтад сургуулийнхаа 537 сурагчийг төлөөлөн сурагчид оролцсон.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Сумын 3 дугаар багийн малчны нэг суурийг сонгон нийт 150 хуц, 58 ухнад үзлэг ангилалт хийв. Ишиг үхээд байгаа дуудлагын дагуу сумын Мал эмнэлгээг зохих арга хэмжээг авч, 11 дээжийг Мал эмнэлгийн Төв лабораторит хүргүүлсэн нь малын хурц хэлбэрийн шөвөг яр гэсэн онош тогтоогдсон учраас сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилон ажиллалаа. Шөвөг ярын вакцинжуулалт 8796 мал 49,6% , үзлэг 67,3% -тай, Цусан халдварт 13588 мал 43,4%, үзлэг 15578 мал 71,4% гэсэн үзүүлэлттэй байна.

Байгаль орчны чиглэлээр: Нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж төрийн байгууллагуудын ажилтан албан хаагчдын 95 хувийн оролцоотойгоор “Нэгдсэн хогийн цэг”-ийг янзлах арга хэмжээг авсан.

Эрүүл мэндийн чиглэлээр: Ковид-19 халдварын эсрэг дархлаажуулалт энэ сарын 2-ний өдрөөс 16-ны өдөр хүртэл хийгдэж дуусгасан. 1-р тунд 1782, 2-р тунд 123 иргэд хамрагдаж 85%-тай вакцинжуулаад байна. Одоо үлдсэн 2-р тунгийн вакцинжуулалт хийгдэх бэлтгэл бэлэн байдлаа хангаад байна.

Аж ахуйн нэгжүүдээр явж халдваргүйтгэл, цэвэрлэгээгээ хийхэд зориулагдах бодисыг яаж хэрэглэх, нүхэн жорлон бохирын цооногт хэрхэн халдваргүйжүүлэлт хийх талаар зөвлөгөө өгч ажилласан.

Соёлын чиглэлээр: Үндэсний бичиг соёлын өдрийг тохиолдуулан “Сайхан монгол бичигтэн гэр бүл”-ийг шалгаруулах цахим уралдаан зарлаж дүгнэсэн.

Мөнххаан:

Төрийн үйлчилгээний чиглэлээр: Цахим үйлчилгээг нийт 27 иргэнд 170900 төгрөгийн лавлагааг гаргаж өгөөд байна. Нотариатын үйлчилгээг нийт 56 хүнд үзүүлээд байна. Иргэний үнэмлэхний лавлагаа 14 хүн, жолоочийн үнэмлэхний лавлагаа 8 хүн, ажилласан жилийн лавлагаа 1хүн, эд хөрөнгийн лавлагаа 1хүн, иргэний үнэмлэх 3 хүн захиалсан.

Улсын бүртгэлийн чиглэлээр: Төрсний 11, нас барсны 1, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 38, иргэний үнэмлэхний олголтын бүртгэл 27, хүчингүй болгосны бүртгэл 22-ыг тус тус бүртгэсэн. Иргэний улсын бүртгэлийн лавлагаа 7 иргэнд олгосон. Мөн төрсний гэрчилгээгээ үрэгдүүлсэн 4 хүүхдэд төрсний гэрчилгээ дахин олгосон. Шинээр ХХК байгуулах 1 иргэнд зөвөлгөө өгч ажилласан. Иргэний улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлт, нөхөн бүртгэл оруулах тухай 5 иргэний мэдээллийг аймгийн улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн. Сонгогчийн шилжилт хөдөлгөөн хийлгэх 30 иргэний материалыг 5 сарын 25 ны өдөр бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн.

Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд: Сумын 2022 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын тэргүүлэх чиглэлийн ажлыг гаргаж багуудын засаг дарга нарт хүргүүлж иргэдээс авах саналын хуудсыг цахимаар болон цаасаар бэлтгэн 5 багийн иргэдээс санал асуулгыг авч ажилласан.

Нийгмийн бодлогын хүрээнд: ГБХЗХГ-аас 15-34 насны залуучуудыг “ОЁДОЛ ЭСГҮҮР”-ийн сургалтанд үнэ төлбөргүй хамруулав.

ГБХЗХГ-аас байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн дарга нарыг арга зүйгээр хангасан онлайн сургалтыг зохион байгуулж төсөвт 5н байгууллага 100% хамрагдав.

ЕБС: Сургуулийн үдийн цай хөтөлбөр болон дотуур байрын сурагчдын хүнсэнд хэрэглэх зорилгоор энэ сард нийт багш ажилчдыг дайчлан сургуулийн эзэмшлийн ногооны талбайд төмс болон бусад хүнсний ногооны тариалалтыг хийсэн.

Боловсролын Чанарын Шинэчлэл – 5 төслийн сонгон шалгаруулалтад “Бага боловсролын сургалтын чанар үр бүтээлийг сайжруулах” чиглэлээр төсөл бичиж 1-р шатанд тэнцээд байгаа бөгөөд 2-р шат эхэлж байгаатай холбогдуулан тухайн төслийг илүү сайжруулан боловсруулах ажлыг удирдлагын багийн зүгээс хэрэгжүүлж эхлээд байна.

Жаахан Шаргын Нутаг үндэсний бичгийн уралдааны Хичээнгүй бичгийн төрөлд тус сургуулийн Монгол хэл Уран зохиолын багш Б.Амарзаяагийн бэлтгэсэн 126 ангийн сурагчид багаараа 3-р байр эзэлсэн.

Элсэлтийн Ерөнхий Шалгалтын давтлагыг энэ сарын 17-ны өдрөөс эхлүүлж, хуваарийн дагуу өдөр бүр танхимаар хичээллүүлж байна.

Коронавирусын вакцинжуулалтад тус сургуулийн 89 багш ажилчдаас 83 хүн буюу 93.2% нь хамрагдаж 1, 2-р тунгаа хийлгээд байна. Мөн тус сургуулийн 12 дугаар ангийн 39 сурагч вакцинжуулалтад хамрагдаад байна.

Хүүхдийн цэцэрлэг: Сургуульд элсэх, бэлтгэл бүлгийн хүүхдүүддээ зориулан “Сэтгэхүй хөгжүүлэх, хэл яриа хөгжүүлэх, зурж, будах, тоглоонгоо хөгжих гэсэн чиглэлээр дасгал ажлын дэвтэр боловсруулан хэвлэж бүлгийн багш нар халдвар хамгааллын дэглэмээ баримтлан гэрээр хүргэж өгөх ажлыг 100% хийж гүйцэтгээд байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: 2021 оны 05 сарын 27-ны байдлаар 14 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Үүний 10 насанд хүрэгчид, 4хүүхэд хэвтэн эмчлүүлсэн. Хүнд хүндэвтэр 2 хүн хэвтсэн.

Урьдчилан сэргийлэх үзлэг 256 байна. Ковид19 вакцины 1,2 тунг өдөр бүр хийж мэдээг ЭМГазар болон бусад газарт мэдээлж байна. Нийт 3138 хүн вакцинд хамрагдахаас 1-р тунд 2665 хүн буюу 84 хувьтай 2-р тунд 852 хүн 27 хувьтай байна. Нийт 3517 хүн хамрагдаад нийт хамрагдалт 112-% тай байна.

5 сард нийт 4 хүний сорьц илгээсэнээр 2 хүн түрхэц эерэг гарч сумын эмнэлгийн хяналтад эмчлэгдэж байна.

Гэрийн ажиглалтанд өнөөдрийн байдлаар халдвартай бүс нутгаас ирсэн 19 хүн хянагдаж байна. Мэдээг өдөр бүр ЭМГ болон мэргэжлийн хяналтын газарт мэдээлж байна. Мөн вакцины 2 тунгаа хийлгээд 14 хоносон болон 72 цагтаа буцах иргэдэд халдвар хамгааллын дэглэмээ сайн мөрдөж байхыг зөвлөж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарлагдсан төсөл хөтөлбөрүүдийн талаар сумын удирдлагуудад мэдээлэл өгсөн. Ажил хайгч 5 иргэний мэдээллийг сэргээсэн.

2018 онд Малжуулах хөтөлбөрт хамрагдсан 3 иргэн 5,610,000 мянган төгрөгийн бүрэн төлөлт хийж дууссан. Мөн 2017 онд Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 1 иргэн 530000 хугацаа хэтэрсэн зээлийг төлж барагдуулсан.

Нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр: ОНОТХҮ-ний төсөл 5-р багийн 1 иргэний төслийг хүлээн аваад Сумын АДЗөвлөлөөр хэлэлцэн батлаад байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэр 59 иргэнд ehalantj системээр олгогдсон. Олголтыг тулган баталгаажууллаа.

Засгийн газраас олгогдож байгаа 300000 мянган төгрөгийн тэтгэмжээ аваагүй 202 иргэний нэрсийн жагсаалтыг ebarimt.mn системээр шалган баталгаажуулж ажилласан. Үүнээс Хүсэлт илгээсэн -41, мөнгө орсон -70, мөнгөөроогүй -58, дансгүй -17 Хүлээгдэж байгаа -16 иргэн байна.

ХЭБҮ-гээр 69 өрхийн 315 иргэний 3,760,000 төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Хүнсний олголтыг түгээлтээр хүргэж байна.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Өндөр насны тэтгэвэрт шинээр Биргэн тогтоолгосон. Эрүүл мэндийн даатгалд 41 иргэн даатгуулж төвлөрсөн харилцах дансанд мөнгийг хийлгэж прогрммд шивсэн. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагатай ААН-дтэй уулзаж төлөх талаар мэдээлэл хүргэсэн.

Мал эмнэлгийн болон ХХАА-н чиглэлээр: Сумын төв ойролцоо хаясан малыг сэг зэм, хог хаягдлыг ЗДТГ-аас томилсон ажлын хэсэг 2 удаа тойрч нийт бод малын 215, бог малын 1200 малыг сэг зэмийг цуглуулан хогийн нэгдсэн цэгт төвлөрлүүлэн хаяж халдваргүйтгэлийг хийгээд байна.

Халзан суманд гоц халдварт шүлхий өвчний сэжиг илэрсэнтэй холбогдуулан Мал эмнэлгийн газрын даргын 2021.05.19 өдрийн 1-65 тоот албан бичгийн дагуу бүх мал эмнэлгүүдэд зөвлөмжийг өгч мал сүрэгт эрүүл мэндийн үзлэг тандалт хийж, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг өгөх үүрэг чиглэл өгсөн. Мал эмнэлгийн тасгаас 2-р багийн 46 өрхөөр орж хашаа хороо болон хаваржааны орчмын цэвэрлэгээг хийх санамж зөвлөмжийг хүргэж ажилласан.

2021.05.27 байдлаар 23 хашаа хорооны 90,2 мянга, 28 худаг уст цэгийн 6,8 мянга, нийтийн эзэмшлийн 56,2 мянга, 215 тээврийн хэрэгслийн 1,2 мянга, 3 түүхий эдийн цэгийн 12,0 мянга, өтөг бууцны 9,2 мянга, сумын төвийн 572 өрхийн 00 болон бохирын цэгийн 12,6 мянга, хогийн цэгийн 5,2 мянга, нийт 193,4 мянган м/кв талбайд халдваргүйтгэлийг хийгээд байна.

Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр: Сумын засаг даргын захирамжийн дагуу “Бүх нийтийн их цэвэрлэгээ”-ний ажлыг 7 хонгийн хугацаанд нэгдсэн зохион байгуулалттайгаар гудамж, эгнээ байр, нийтийн эзэмшлийн газруудад иргэд айл өрх, төсөвт 5-н байгууллага, 17-н аж ахуй нэгжүүд хамтран ажилласан. Үүнд 70 тн хог хаягдлыг зайлуулж, шатах тослох материалын 950000 төгрөгийн зардал гарсан.

Ногоон байгууламж, ургамал, бэлчээрийн талаар: “Бүх нийтээр мод тарих” өдрийг сумын хэмжээнд “Өрх бүр хашаандаа 3-5 мод таръя” уриатайгаар зохион байгуулсанаар 591 модыг 1 албан байгууллага, 72 өрхийн 144-н иргэд мод тарьж 1461200 төгрөгийн зардал гарсан байна.

Баянтэрэм багийн Наран Сарангийн талд Дундговь аймгийн отрын 4000 адуу орж ирснийг сумын цагдаагийн хэсэг ЗДТГ-ын холбогдох мэргэжилтэн нар хамтарч нутаг чөлөөлөлт хийсэн. Мөн 2021 оны 05 сарын 25 нд сумын ЗДТГ-аас Баянцагаан, Бүрэнцогт багийн нутаг дэвсгэрт отроор орж ирсэн 7 өрхөд 2021 оны 06 сарын 05 ны дотор нутаг чөлөөлөх мэдэгдэл хуудас өгч ажилласан.

Наран:

Сумын онцгой комиссын шийдвэрээр 1 суурин, 3 хөдөлгөөнт пост ажиллуулж иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж ажиллаж байна.

Засаг дарга болон Тамгын газрын дарга, холбогдох албан тушаалтнуудад хандаж 5 өргөдөл гомдол ирж шийдвэрлэгдсэн 4, Шийдвэрлэлт 80 хувьтай байна.

Боловсролын чиглэлээр: СӨБ: Зуны амралт эхэлж байгаатай холбогдуулан хүүхэд эцэг эхчүүдэд “Таньд хүргэх ил захидал”-ыг хүргэсэн. Хандалтын тоо - 82.

Ерөнхий боловсролын чиглэлээр: Бага дундын ЗАН-ийн багш нар хамтран 1,2-р багийн нутгаар суурь тойрч сурагчдын теле болон цахим хичээл, багшийн өгсөн даалгаврын сан, тараах материалын үр дүнтэй танилцаж заавар зөвлөгөө өгч ажилласан. Нийт 107/бага анги-80, дунд анги-27/ сурагчдын теле хичээлийн тэмдэглэлийг шалгаж зөвлөгөө өгсөн.

Насан туршийн боловсролын төвөөс зохион байгуулсан “Угийн бичиг”-ийн цахим сургалтанд нийт 18 багш, ажилтан хамрагдсан.

“Зуныг зугаатай өнгөрүүлцгээе” зуны даалгаврын хүүхэд хамгааллын зөвлөмжийг бэлтгэн эцэг эх, асран хамгаалагч нарт нийт 150ш гаргаж хүргүүлсэн.

“Байгальдаа ээлтэй хандъя” чэлленжид төрийн албан хаагчид болон сургуулийн сурагчид, анги хамт олон байгаль эхээ хайрлан хамгаалах үйлст нэгдэж сумаа хоггүй сум болгох нөлөөллийн сайн үйлсийг үргэлжлүүлэн ажиллуулж байна.

Мал эмнэлгийн чиглэлээр: 2-р багийн хуц-228, ухна-90 нийт 318, 1-р багийн хуц-140, ухна-56 нийт 196 хээлтүүлэгчид үзлэг хийж ангилсан.

Ариутгал халваргүйтгэл хийсэн талбайн хэмжээ-149520м²

Байгаль орчин, газрын харилцааны чиглэлээр: 2021.03.23-ны өдрийн А/22 тоот захирамжаар 7 байршилд газрын дуудлага худалдааг зарлан цахим биржид зураг, байршил

зарыг оруулж, 6 байршилд оролцогч бүрдсэний дагуу хугацаандаа амжилттай зохион байгуулагдан хаалаа.

2021 оны 4сарын 29-ны А/36 тоот захирамжаар Худалдаа үйлчилгээний газар, төв цогцолбор зориулалтаар 1 байршилд газрын дуудлага худалдааг дахин зарлаж цахим биржээр дуудлага худалдаа явагдлаа. Нийт дуудлага худалдааны төлбөрийн орлого 8.090.000 төгрөгийг төрийн сангийн холбогдох данснуудад төвлөрүүлсэн.

Дуудлага худалдаагаар газар эзэмших иргэний- 5, шинээр газар эзэмших-3, өргөдлийн дагуу эзэмших -2, өргөдлийг тус тус хүлээн авч бүртгэн 5 өргөдлийг засаг даргын захирамжийн төсөл төлөвт шилжүүлээд байна.

3 иргэний газар өмчлөх, 2 иргэний үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ авах захиалгыг хүлээн авлаа.

Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд иргэд ААН, албан байгууллага, иргэдээс 6 төрлийн модны 320 ширхэг суулгацны захиалга авч сумын хэмжээнд 350ш мод тарьлаа.

Бүх нийтийн их цэвэрлэгээнд 5 албан байгууллага, 100 гаруй иргэд хамрагдаж 100 га талбайгаас 2 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн. 12 золбин нохойг устгалаа.

Эрүүл мэндийн чиглэлээр: “Ковид-19” өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад нийт-1121 иргэн хамрагдахаас төрийн албан хаагчид 1,2-р тунг 100%, 50-аас дээш насны ахмадууд болон 18-49 насныханд 1-р тунд нийт-945 иргэнийг вакцинжуулсан.

Голомттой бүсээс ирсэн иргэдийг гэрийн ажиглалтанд авч тандалт хийж, 11 машиныг ариутгаж халдваргүйжүүлсэн.

Түвшинширээ:

Сумын Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/50 “Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай” захирамж гаргаж түргэвчилсэн оношлуураар “Сул эерэг” үзүүлэлттэй гарсан иргэдийн шинжилгээний PCR шилжилгээний хариу гартал хязгаарлалтын дэглэм тогтоож, сумаас орох гарах болон сум доторх хөдөлгөөнийг зогсоож хүнсний дэлгүүрүүдийг хүргэлтийн үйлчилгээний зохион байгуулалтанд оруулан ажиллалаа. 05 дугаар сарын 07-ны А/51 “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” сумын Засаг даргын захирамжаар 06 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг /улбар шар/-д шилжүүлээд байна.

05 дугаар сарын 08-аас эхлэн сумын орох гарах хөдөлгөөнийг хязгаарлан хянах зорилгоор 2 хөдөлгөөнт постыг Улаанбаатар болон Сүхбаатар аймаг руу зорчдог замуудад гарган ажиллаж байна. Хөдөлгөөнт постуудад төрийн байгууллагын албан хаагчид жижүүрлэн ажиллаж байна. Хөл хорио тогтоосонтой холбогдуулан хөдөлгөөнт болон хяналтын постуудын бензин шатахууны зардалд одоогоор 5,0 сая төгрөгийн зардал гараад байна.

2021 оны 05 дугаар сарын байдлаар сумын нийт хүн ам 3420, сумын нийт өрх 976, шинээр төрсөн хүүхэд 19, нас барсан 5 хүн бүртгэгдсэн байна.

Сумын Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөлийг шинэчлэн байгуулаад байна.

Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны №08 дугаар тогтоолоор сонгуулийн хэсгийг байгуулан, сумын сонгуулийн салбар хорооны 2021 оны №01 дүгээр тогтоолоор хэсгийн хороодыг томилон ажиллаж байна. Нийт 45 төрийн албан хаагч сонгуулийн сумын салбар болон хэсгийн хороодод ажиллаж байна.

Хөрөнгө оруулалтын чиглэлээр: Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар ковш болон хог зөөврийн машин, Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар Хог зөөврийн машин худалдан авах тендерүүдийг тус тус зарлан тендер нээх, хянан үзэх, үнэлэх ажлыг үнэлгээний хороодоор зохион байгуулж, ковш болон хог зөөврийн машины тендер “Оттомир” ХХК, хог зөөврийн машины тендер “Оточ – Оргил” ХХК нар шалгарч гэрээ байгуулах эрх олгох албан

тоотыг хүргүүлээд байна. Мөн аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар ундны ус зөөврийн машинтай болоод байна.

Улсад төвлөрүүлэх төвлөрсөн төсвийн орлогод 1450,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2057,7 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 141,9 хувиар, аймаг төвлөрүүлэх төвлөрсөн төсвийн орлогод 32825,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 38326,3 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 116,8 хувиар, сум орон нутгийн татварын орлогод 8016,7 мянган төгрөг төвлөрүүлэхээс 16604,3 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 207,1 хувиар тус тус биелүүлэн ажилласан.

Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр: Бүх нийтийн их цэвэрлэгээг 5 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулан албан байгууллага айл өрх нийлсэн 260 гаруй хүн сумын төв болон хогийн цэг, болон ойр орчмын 4 км радиус дахь хог хаягдлыг түүж цэвэрлэсэн.

Хавар, намрын улиралд мод тарих үндэсний өдрийн хүрээнд албан байгууллага, ААНэгж, айл өрхүүд нийт 930 гаруй мод тарьсан байна.

Мөн сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ногоон байгууламжийг нэмэгдүүлэх 20,0 сая төгрөгийн өртөг бүхий ажлын хүрээнд хуучин цэцэрлэгт хүрээлэнгийн шаардлага хангахгүй хашаа хайсийг авч шинэ хашаа хайс татаж, 200 ширхэг мод бут нөхөн тарилаа.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж: Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д бүртгэлтэй ажил хайгч 2021 оны 05-р сард шинэ ажлын байранд 3 иргэний мэдээллийг зуучилсан.

ХЭДС-аас жил бүр зарлагдах санхүүгийн дэмжлэг олгох линкийг сумын группт байршуулж хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэгийг сонирхож буй иргэдийг бүртгэж ажилласан. Үүнд: "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих" хөтөлбөрт-2 иргэн, "35 ба түүнээс дээш насны иргэний ажлын байрыг дэмжих" хөтөлбөрт-7 иргэн, "Ахмад настаны зөвлөх үйлчилгээний хөтөлбөр"-т 2 иргэн нийт 11 иргэн бүртгүүлсэнээс 5 иргэний төслийг ХХҮГ-т хүргүүлээд байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 26 өрхийн 117 иргэн хамрагдаж байгаа ба 05-р сарын 1,448,000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнээ бүрэн авсан. Мөн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч буй өрхүүдийн цахим картыг сумын төрийн банктай хамтран 26 өрхөөс коджуулалт бүрэн хийгдсэн.

Нийгмийн халамжийн үйлчилгээний асаргааны тэтгэмжид сунгалт ахмад 3 иргэнийг тэтгэмжид хамруулсан. ОНОТХҮ-ний бүлгийн төслийн сонгон шалгаруулалтыг сумын амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцэн 4 бүлгийн төслөөс 2 өрхийн төслийг сонгон шалгаруулан холбогдох баримт бичгийг бүрдүүлж аймгийн ХХҮГ-т хүргүүлсэн.

Нийгмийн даатгал: ЭМД-д 22 хүний 3156280 төгрөг, сайн дурын даатгалд 40 хүний 6958950 төгрөг төвлөрүүлэв. НДШ-д 8-н байгууллагын 869400 төгрөгийн орлого орж байна. Одооны байдлаар НДШ бүрэн ороогүй байна. 04 сарын тэтгэвэрт 2 банкаар 412 хүнд 142397,3 сая төгрөгний тэтгэвэр олгосон. Тэтгэмжид 5 хүнд 6916989 төгрөг олгосон. Оршуулгын тэтгэмжид 1 хүнд 1000,0, жирэмсэн амаржсны тэтгэмжид 2 хүний 157758 төгрөг олгосон. COVID-19 буюу цар тахалтай холбоотойгоор ЗГ-аас ААНэгжүүдийг НДШимтгэлээс чөлөөлнө гэсний дагуу 16 ААНэгжийг чөлөөлөлтөд хамрагдуулсан.

Соёлын төв: Сумын засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Монголын нууц товчоо, хуур, номын сан, угийн бичиг хөтөлдөг айл өрхийн судалгааг авч байна.

Сүхбаатар аймгийн ахмадын холбооноос зохион байгуулж буй цахим дууны уралдаанд 10 ахмадын дууг бэлтгэж ахмадын холбооны цахимд байршууллаа.

Боловсрол: Бага ангийн багш нар сурагчдын хоцрогдлыг арилгах судалгаанд хамрагдаж түүн дээрээ үндэслэж Сурлагын тэтгэлэгт хөтөлбөрийн 5-р шатанд "Эрдмийг

хичээлээр сурдаг " сурлагын хоцрогдол арилгах төсөл бичиж холбогдох газарт хүргүүлээд байна.

Ирэх намар 1-р ангид орох 97 хүүхдэдээ сургуульдаа ирж суралцах урилгыг бэлтгэж багийн дарга нараар дамжуулан хүүхэд бүхэнд хүргүүлээд байна.

42 суралцагчид Суурь боловсролын гэрчилгээг олгосон. Үүнээс 29 суралцагч бүрэн дунд сургуульд суралцах боллоо.

180м² талбайд 10 төрлийн хүнсний ногоо, 125м² талбайд төмс суулгаж, 8х3 харьцаатай гар доорх материалаар хүлэмж хийлээ. Мод тарих өдрөөр хичээлийн II-р байрны хашаанд 50 ширхэг хайлаас мод тарьж суулгалаа. Боловсролын 100 жилийн ойд зориулж "Боловсролын төгөл" үүсгэн бий болгож багш бүр 1 ширхэг улиас мод тарилаа.

Хүүхдийн цэцэрлэг нь мод тарих өдрөөр өмнөх онд тарьж ургуулсан 78 ширхэг мод, өөрийн эзэмшил газарт 88 ширхэг, үхрийн нүд 3, нийтийн эзэмшил газарт 37 ширхэг буюу нийт 206 ширхэг модыг тарьж арчилж өдөр бүр услаж байна.

4х6 хэмжээтэй хүлэмж барьж 7 төрлийн нарийн ногооны үрсэлгээ хийж байна. Цэцгийн мандал 96 м² талбайд үрсэлгээ хийж, тасалгааны цэцэг 90 ширхэг тарьж ургуулж байна.

Монгол бичгийн дугуйланг ЕБС-ын МХУЗ-ын багш 7 хоног бүрийн 3,5 дах өдөр бүр тогтмол хичээллүүлж байна.

Эрүүл мэнд: Амбулаторийн нийт үзлэг 414, алсын дуудлага 7, гэрийн дуудлага 12, хэвтэн эмчлүүлэгч 8, Нас баралт 0.

Covid-ийн вакцинжуулалтыг төрийн албан хаачдад 2-р тунг, 1-р тунг 18-с дээш насны нийт иргэдэд хийгээд байна. Үүнд: 1-р тунг 1910 хүнд, 2-р тунг 145 хүнд бүгд 2055 хүнд хийгээд байна.

Түмэнцогт:

Ковид-19 цар цахалтай холбоотой Улсын Онцгой комиссын албан даалгавар, ЗГ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамжийн хүрээнд холбогдох арга хэмжээг авч цахимаар 56 төрлийн мэдээллийг сумын 3 группээр дамжуулан иргэдэд хүргэсэн.

Шинэчлэгдэн найруулагдсан хууль тогтоомжийн талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд цахимаар 3 төрлийн мэдээлэл 20 гаруй удаагийн давтамжтай хүргэсэн.

Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах орон тооны бус зөвлөл байгуулж худалдаа үйлчилгээ эрхэлдэг ААНэгжүүдэд хяналт тавьж, заавар зөвлөмж, сургалт зохион байгуулах төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Байгаль орчны чиглэлээр: Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2 ААНэгж, 2 иргэний уст цэг хийж зөрчил дутагдлын талаар албан шаардлага хүргүүлэн, заавар, зөвлөмж өгсөн.

"Эх дэлхийн өдөр"-т зориулж "Хар ямаатын БНГазрын захиргаа"-тай хамтран айл өрхийг хашаандаа төрөл бүрийн мод тарихийг уриалах, дэмжлэг үзүүлэх, жишиг гудамж бий болгох арга хэмжээний хүрээнд 5н3 өрхөд монос, гүйлс, үхрийн нүдний суулгац 240 ширхэгийг суулгаж өгч, мод тарих арга, арчилгаа, усалгааны хуваарийн талаар зөвлөгөө өгсөн.

Хөдөө аж ахуй: 2021.05.07-ны өдрийн сумын онцгой комиссын 9-р хурлын шийдвэрээр өгсөн үүрэг чиглэлийн дагуу 16 ААНэгж, дэлгүүрүүдийн дарга эрхлэгч нартай уулзалт хийж Covid-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж хяналтыг тавьж ажиллалаа. Хүнсний худалдаа эрхлэгчдийн 22 худалдагчийг вакцинд 1-р тунд хамруулсан.

COVID -19 цар цахалтай холбогдуулан хүнсний худалдаа эрхлэгч аж ахуйн нэгж дэлгүүрүүд цаасан бүртгэл болон QR кодыг ашиглан үйлчлүүлэгчдийн бүртгэлийг хийж хэвшээд байна.

"Хоршоонд суурилсан хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэл" төслийн хүрээнд 285 малчин өрхөөр 4 ажлын хэсэг сургалт сурталчилгаа хийж гарын авлага материалыг хүргүүлж ажиллалаа.

Аймгийн ХХААГазраас 1 тн үрийн төмсийг хөнгөлөлттэй үнээр худалдан авч 15 өрхөд олгоод байна.

Сумын хэмжээнд газар тариалан эрхлэгч 4 ААНэгж 2300 га-д улаан буудай, 1200 га-д тэжээлийн ургамал тариалалт хийхээр мэдээ өгөөд байна.

8. Сумын хэмжээнд том малын зүй бусын хорогдол тэмээ – 3, адуу – 363, үхэр - 677, хонь - 1678, ямаа – 1594, нийт – 4315 толгой мал хорогдож сумын нийт малын 3.1%-ийн хорогдолтой байна. Мөн мал төллөлт 71%-тай байна.

Мал эмнэлэг: Сумын Засаг даргын 2021оны 03 дугаар сарын 22-ны А/21 тоот захирамжийн дагуу Сумын мал эмнэлгийн тасаг, хөдөө аж ахуйн тасаг, байгаль орчны байцаагч, багийн Засаг дарга нартай хамтарч албан даалгаврын дагуу хийгдэх ажлын төлөвлөгөө, гарган сэг зэм устгал, халдваргүйтгэлийн ажлыг хийгээд байна. Сумын төвийн ойролцоо болон хөдөөгийн 1, 2-р багийн нутагт хаясан малыг сэг зэм, хог хаягдлыг ЗДТГ-аас томилсон ажлын хэсэгтэй 2 удаа тойрч Адуу-331 Үхэр- 609 Тэмээ-3 Хонь-1606 Ямаа-1398 нохой-36 Нийт-3983 сумын хэмжээнд /92,4%тэй/ малын сэг зэмийг цуглуулан нэгдсэн хогийн цэгт болон баг дээр нь зөвшөөрсөн цэгт нийт 41,6 тонн хог хаягдал төвлөрлүүлсэн. Ариутгал халдваргүйтгэлийг 120,8 мянган м/кв талбайд халдваргүйтгэлийг хийгээд байна. Эдгээр арга хэмжээнд 43 цаг ажиллаж 850 л түлш, 24 л масло, 20 л тосол шатах тослох материал, 12 кг халдваргүйтгэлийн бодисыг зарцуулсан бөгөөд нийт 2.027.000 төгрөг зарцуулсан.

Коронавируст /ковид-19/ цар тахалаас урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн зам талбай-10,000 м² байр орон сууцанд- 15630 м² муу усны нүх, жорлон-2300 м² худаг уст цэг-16ш 1850 м² нийт-25480 м² 29780 м² ариутгал халдваргүйтгэл хийгдээд байна.

Аймгийн мал эмнэлгийн газраас төлөвлөгөөт тарилга болох шөвөг ярын тарилга 2000 тун шаардлагатай ариутгалын бодис татан авлаа.

Хөдөлмөр, нийгмийн халамжийн чиглэлээр: Ажил хайгч 2 иргэний мэдээллийг “LIMS” праграммд шинэчилж бүртгэсэн. Санхүүгийн дэмжлэгт хамрагдаж 2020 оны эргэн төлөлт төвлөрүүлэлт дутуу хийсэн 12 иргэнд мэдэгдэл хуудас хүргүүлж 11447750 төгрөгийг төлүүлэхээс 11297750 төгрөгийг төлүүлсэн. Мөн 2021 оны 5 сард эргэн төлөлт хийх иргэдээс 150000 төгрөгний эргэн төлөлтийг төвлөрүүлээд байна.

2021.05.18-ны өдөр ХХҮГазраас зохион байгуулсан онлайн хуралд хамрагдаж зөвлөмж чиглэлийн дагуу өгсөн үүрэг даалгаварыг биелүүлж ажилласан.

Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах төслийг нөөц бааз суурь дээрээ тулгуурлан сумын Засаг дарга 600000 төгрөгний үнэ бүхий 10 шуудай төмсийг зорилтот бүлгийн 10 иргэнд хуваарилан өгч тариулах ажлыг зохион байгуулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн хүрээнд нийт 4 төсөл хүлээн авсан. Нийтийг хамарсан ажлын хүрээнд ЗДТГазраас ногоон байгууламж нэмэгдүүлэх, булаг шанд хашиж сэргээх гэсэн 2 төсөл ХХҮГазарт хүргүүлсэн.

1-р багийн өрхүүдээр явж хөдөлмөр эрхлэлээс зарлагдсан төсөл хөтөлбөрийн талаар мэдээлэл өгч ХЭДСангийн төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдэд эргэн төлөлтийг хуваарийн дагуу хийх талаар мэдэгдсэн.

“Түмэнцогт суманд үйлдвэрлэв” борлуулалтын цэгт 11 иргэний бараа бүтээгдэхүүнийг борлуулж нийт 1265000 төгрөгний борлуулт хийж тус цэгийн цахим хуудсанд мэдээ, мэдээлэл оруулж иргэдэд бараа бүтээгдэхүүнийг сурталчилан ажиллаж байна.

Нийгмийн халамж: Хүнсний эрхийн бичгийн 5 сарын олголтыг 45 өрхөөс 42 өрхөд олгож, 38 өрх ХЭБичгийн картаа пин коджуулах ажил хийсэн. Хүнсний эрхийн бичгийн 5 сарын олголт болон коджуулалтын мэдээг бүрийн 15 цагт мэргэжилтэнд мэдээллэж ажилласан.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд 3 бүлэг өрхөөс төсөл ирснийг сумын амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцэж шалгарсан төслийг холбогдох

баримт бичгийн хамт мэргэжилтэнд хүргүүлсэн.

2021.05.19 болон 20-ны өдрүүдэд хөдөөгийн баг болох 1-р багийн 50 гаруй өрхөөр орж нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж, Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг хүргэж ажилласан. Мөн 2-р багийн өрхүүдээр явсан мэргэжилтэнүүдээр дамжуулж гарын авлага хүргүүлсэн. Нурууны бүс шаардлагатай 6 ахмад настан, 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өвдгөвч шаардлагатай 4 ахмад настан, рашаан сувилалд амрах хүсэлтэй 3 ахмад настан байна.

Сумын хэмжээнд 300000 төгрөг нь ороогүй байгаа 102 иргэний жагсаалт ирсэнийг тулгаж дансгүй болон нэр данс зөрүүтэй иргэдийн мэдээллийг шинэчлэн засаж дансны иргэдийн дансыг харилцагч банк болон иргэдтэй холбоо барьж авч ХХҮГазрын дэд даргад тулгасан жагсаалтыг хүргүүлсэн.

5. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн тулгалтийг цаг тухай бүрт хийн нөхөн олголтыг холбогдох мэргэжилтэнд хүргүүлж ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургууль: 12-р ангийн 34, 9-р ангийн 46 нийт 80 сурагч энэ жил төгсөж байна. Төгсөгчдийн боловсролын гэрчилгээ хэвлэх, олгох ажил зохион байгуулагдаж байна.

Элсэлтийн ерөнхий шалгалт өгөх суралцагчдын Эцэг эх, асран хамгаалагчаас санал асуулга авч, санал асуулгын дүн, давтлагын хуваарь, үүрэг, оролцоог танилцуулан онлайн хурал хийж 35 эцэг эхийг хамрууллаа.

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Тогтвортой хөгжлийн боловсрол”-2 төлийн нэгдсэн арга хэмжээний нээлттэй форум, хэлэлцүүлэгт 33 багш, 3 удирдах ажилтан цахимаар 5 өдрийн турш 100 хувь хамрагдсан байна.

Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэлийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг “Үжин” төвийн тэргүүн Я.Ундраагийн зохион байгуулсан Анги удирдсан багш нарт зохион байгуулсан сургалтанд 22 анги удирдсан багш, байрын багш, нийгмийн ажилтан нийт 24 багш 100 хувь хамрагдаж мэргэжлийн зөвлөгөөг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сүхбаатар аймгийн ГБХЗХГазраас зохион байгуулсан аймгийн хүүхдийн оролцооны байгууллагын “Оролцоод хөгжье” хүүхдийн цахим чуулганд 8-9-р ангийн 5 суралцагч сумаа төлөөлөн оролцсоны зэрэгцээ 9а ангийн суралцагч Б.Нарансолонго сумын суралцагчдыг төлөөлөн “ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ – ХӨДӨӨ ОРОН НУТАГТ” сэдэвт илтгэл тавьж оролцсон.

“Боловсрол-100” аяны хүрээнд ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор сургуулийнхаа эзэмшлийн талбайд 100ш гүйлсийг багш, ажилчдаар тариулж, сумынхаа нийтийн эзэмшлийн талбайд 100ш улиас, 35ш гүйлс суулгалаа. Сургуулийн эзэмшлийн талбайд төмс, шар манжин, хүрэн манжин, сонгино, лууван зэрэг хүнсний ногооны үрийг 100м² газарт суулгаад байна.

Сургуулийн Хүүхэд хамгааллын багаас “Хүүхдийн аюулгүй байдал”-ыг хангах талаар 7 төрлийн ЗӨВЛӨМЖ боловсруулж, эцэг эхчүүдэд хүргээд байна.

Цэцэрлэг: Сургуульд бэлтгэгдсэн байдалд дэмжлэг үзүүлэх арга зүйн санаа сэдвийн хүрээнд сумдын бүсийн хэлэлцүүлгийг 7 удаа, аймгийн СӨБ-ын багшийн хэлэлцүүлгийг 6 удаа зохион байгуулж давхардсан тоогоор аймгийн хэмжээнд 287 багш, түмэнцогт сумын бүлгийн багш нар давхардсан тоогоор 13 удаагийн хэлэлцүүлэгт бүлгийн бүх багш нар 100% хамрагдсан байна.

5 настай хүүхдийг сургуульд бэлтгэх бэлэн байдлыг хангах, эцэг эхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр сүхбаатар аймгийн бэлтгэл бүлгийн багш нар нэгдэн сумдын бүсээрээ \хойд бүс: будах, эцэг эхэд өгөх зөвлөгөө, зүүн бүс- бичих, хөдөлгөөнт тоглоом, урд бүс- зурах, наах, баруун бүс – сэтгэхүй, барьж байгуулах\ гэсэн хүүхдийн хийх үйлээр сургуульд бэлтгэгдсэн байдалд дэмжлэг үзүүлэх чиглэлээр 6 долоо хоногийн дасгал даалгаврыг боловсруулан 1 долоо хоног 10-12 хуудастай нийт 72 хуудас дасгал даалгаврын багцыг 7 хоног бүр бэлтгэл А, Б бүлгийн 61 хүүхдээс 57 хүүхдэд бүрэн тарааж 93%-тай т нэгдсэн журмаар тараалаа.

Теле хичээлийн үзэлтийн тандалтын мэдээг 7 хоног бүр нэгтгэн аймгийн БСУГ-т явуулж манай цэцэрлэгийн хүүхдүүдийн теле хичээлийн үзэлт 5-р сарын 10ны байдлаар 6 сарын дунджаар 74,1%-тай байна.

Бүлгийн багш нар 5-р сард мэдлэг ур чадвараа нэмэгдүүлэх, заах арга зүйгээ сайжруулах улсын хэмжээний 2 сургалтад 3 багш, аймгийн бүсийн 4 хэлэлцүүлэгт 7 багш хамрагдсан байна.

2020-2021 оны хичээлийн жилд эцэг эхээс бэлтгэсэн сургалт, ариун цэврийн үлдэгдлийн тооцоог хийж эцэг эхэд хүлээлгэн өгч зуны амралтаар хийх дасгал даалгаврыг Дунд А,Б бүлгийн 39 хүүхдэд \ 1 хүүхдэд 10 хуудас\ 390 хуудас даалгаврыг тараан өглөө.

“ДЭЛХИЙН ТОМ ХИЧЭЭЛ” үндэсний хэлэлцүүлэгт уралдаанд “ Солонгон аашт резин” сэдэвт хичээлээр оролцон аймгийн бүсээс шалгаран улсад амжилттай оролцлоо.

Ковид-19 эсрэг дархлаажуулалтын вакцины I, II-р тунд нийт 22 багш ажилтан, 88%-тай хамрагдсан байна.

“ХОГГҮЙ ТҮМЭНЦОГТ” уриалгад нэгдэн байгууллагын эзэмшил талбайн гадна болон дотор талбайн хог, өнжмөл шар өвсийг цэвэрлэж мөн аяны хүрээнд “ХАР ЯМААТ” –ын ууланд байрлах уурхайн амны хогийг нийт багш ажилчид бүрэн бүрэлдэхүүнээрээ очиж цэвэрлэлээ. Уг аяны хүрээнд нийт 2 удаа байгууллага орчмын хог, 1 удаа байгалийн нөөц газрын хог, багш ажилтан бүр өөрийн амьдарч буй гэр, байшин орон сууцны ойр орчмын хогийг цэвэрлэж “ХОГГҮЙ ТҮМЭНЦОГТ” уриалгад нэгдэн өөрсдийн хувь нэмрээ оруулсан байна.

1. “СЭТГЭЛИЙН БЭЛЭГ” аяныг байгууллагын хүрээнд зохион байгуулж бэлтгэл А бүлгийн туслах багш Ш.Гэрэлцэцэгт 2 машин аргалыг түүж сэтгэлийн хандив өргөлөө.

ЭМТөв: Эрүүл мэндийн төвийн амбулаториор 301 иргэн, алсын дуудлагаар 17 , ойрын дуудлагаар 130 үйлчлэгч үйлчлүүлж, 14 иргэн хэвтэн эмчлүүлсэн байна. Товлолт дархлаажуулалтанд 100%, хамруулсан.

Энэ сард голомт бүхий бүс нутгаар зорчсон 135 иргэнийг бүртгэн авч мэдээллийг ЭМГ-т явуулж 85 иргэнийг гэрийн ажиглалтанд авч тогтмол хянаж түргэвчилсэн оношлуураар шинжилгээнд хамруулж ажиллав.

Ковид 19 халдварын эсрэг дархлаажуулалтанд хамрагдвал зохих нийт иргэний 97 хувийг хамруулаад байна

Цахим төр, лавлагаа мэдээлэл: Гэрлэлт бүртгэлгүй тухай лавлагаа 2 , Иргэний үнэмлэхийн лавлагаа 10 , Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт 4, Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа 6 , Үл хөдлөх эд хөрөнгөтэй эсэх лавлагаа 3, Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт (Иргэн) 14 , Жолоочийн лавлагаа, мэдээлэл 5 , Вакцины гэрчилгээ 1 , Иргэнд олгох тодорхойлолт 2 үүнээс төлбөртэй 39 төлбөргүй 8 нийтдээ 47 лавлагаа гаргасан.

ERP-ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН НЭГДСЭН СИСТЕМ-ийн сургалтад ЗДТГ-ын 26 албан хаагчид хамрагдан ашиглаж байна.

Халзан:

УИХ-ын тамгын газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн Монгол Улсад төлөөллийн байгуулагыг бэхжүүлэх нь төслийн нэгжээс аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч нарыг чадавхжуулах, суурь мэдлэг олгох цахим сургалтыг Нутгийн удирдлагын эрх зүйн үндэс, Орон нутгийн төсвийн удирдлага, байгаль орчин гэсэн үндсэн 3 сэдвээр нийт 6 цагийн сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан. Үүнд сумын ИТХ-ын төлөөлөгчдийн 83.3%-ийн ирцтэй хамрагдсан.

Сумын ИТХ-ын ээлжит бус 5 дугаар хуралдаан болж нийт 15 төлөөлөгчдийн 100% ирцтэй хуралдан Бэлчээрийн маргааныг хянах, зохицуулах журам батлах тухай, Хог хаягдалын хураамжыг тогтоох тухай, Малын эрүүл мэнд дэд хөтөлөр батлах тухай, Сум

хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэлийг батлах тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр: Аймгийн Засаг даргын 262 дугаар тоот захирамжын дагуу Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор нийт байнгийн 4 постод ээлжээр 16 албан хаагч, хөдөлгөөнт эргүүлд цагдаагийн 1 албан хаагч ажиллаж байна. Зэргэлдээх сумдад халдварын тохиолдол бүртгэгдэж байгаатай холбогдуулж урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн Аймгийн онцгой комиссоос ирүүлсэн албан тоотуудыг хүлээн авч, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. 5-р сарын байдлаар Халзан суманд өвчлөл бүртгэгдээгүй байна.

КОВИД-19-ийн эсрэг дархлаажуулалтад хамрагдах тус сумын харъяалал бүхий 18-аас дээш насны 1238 иргэн бүртгэлтэй байна. Үүнээс 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 10:00 цагийн байдлаар 105 иргэн бүрэн тунг тариулсан, 1088 иргэн 1-р тунгаа тариулсан байна. /бусад газарт дархлаажуулалтад хамрагдсан 132/.

Сумын ЗДТГ-ын дээвэр засварын ажлыг "Хүрэл Соёмбо" ХХК-аар гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.

Сонгуулийн хорооны салбар зөвлөлийг 6 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулаад байна.

Аймгийн хэмжээнд сар бүрийн 25-ны өдрийг "Залуучуудыг дэмжих өдөр" болгон зарласантай холбоотойгоор Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг шинэчлэн батлаж салбар зөвлөлийг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Төсөв, санхүү: Энэ сард аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 40782,3 мянган төгрөг ирсэн. Орон нутгийн байгууллагуудын санхүүгийн дэмжлэгээр:

- ЗДТГ-29335,9
- ИТХ-5697,6
- Соёлын төв-6236,7 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна.

Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагуудын хувьд:

- ЕБС-41233,6
- СӨБ-21237,4
- ЭМТ-30111,5,ЭМД сангаас 859,5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аймгийн Санхүү, хяналт аудитын газраас хийж буй төлөвлөгөөт шалгалтад бүх төсөвт байгууллага, Халзан дулаан ОНӨҮГ хамрагдаж байна.

Хууль эрх зүй: МХГ-аас зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага", "Угийн бичгийг хөтлөх нь" сэдэвт сургалт, 5 сарын 7 ны өдөр АТГ-аас зохион байгуулсан "Авлигын эсрэг" цахим сургалт, ГБХЗХГ-с зохион явуулсан "Байгууллагын эцэг эхийн зөвлөл"-ийг чадавхжуулан цахим сургалт, ТАЗ өөс зохион байгуулж буй долоо хоног бүрийн 4 дэх өдрийн сургалтуудад тус тус хамрагдлаа.

Ерөнхий боловсролын сургууль: БСШУЯ-ны сайдын тушаал, БСУГ-аас гаргасан зөвлөмж чиглэлийн дагуу сурагчдын улиралын амралт эхэлсэнтэй холбогдуулан дотуур байранд амьдарч байсан сурагчдын үлдээсэн гутал хувцас, эд материалыг эцэг эх асран хамгаалагчдад хүлээлгэн өгсөн.

Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор сургуулийн гадна талбайд 60ш модыг суулгасан. Багш ажилчид, төгсөх ангийн сурагчдын хамтаар дотуур байрын сурагчдын хоол хүнсэнд хэрэглэх зорилгоор төмс, лууван, манжин зэрэг хүнсний ногоог тариалсан.

Эрүүл мэндийн төв: Нийт 56 иргэнийг "Гэрийн ажиглалтад 7 хоног тусгаарлан тандалтыг хийж өдөрт 2 удаа биеийн байдлыг хянан ЭМГ-т мэдээлж ажиллалаа. Хугацаа дуусмагц түргэвчилсэн шинжилгээ хийж, хариу нь сөрөг гарсан иргэдэд дэглэмээ барих, маскаа тогтмол зүүх, зайгаа барих зөвлөгөө зөвлөмж өгч хяналтаас гарган ажиллав.

Сургууль, цэцэрлэг, ЭМТ, Цагдаа, онцгой комиссын албан хаагчдыг Ковид -19 өвчнөөс сэргийлэх вакцины 1,2 тунд бүрэн хамруулаад байна. Нийт 1244 вакцинаас 1232 вакцин хийж

99% тай байна. Мөн 2-р тунгаа хийлгэсэн 106 иргэн байна. 8,5 % байна. 5 дугаар сарын 26,27,28,29,30 ны өдрүүдэд вакцины 2-р тун хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Соёлын төв: “Жаахан шаргын нутаг” монгол бичгийн онлайн уралдаанд байгууллага хамт олноороо идэвхитэй оролцлоо.

Хөдөлмөр халамжийн чиглэлээр: WAIS програмд байнгын асаргааны сунгалт хийлгэж байгаа 2 иргэн, Шинээр байнгын асаргаанд орж байгаа 1 хүүхэд, 1 өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Тэргэнцэрийн захиалгын материалыг цахимаар хүргүүлж сунгалтыг хийсэн. E halamj програмд Жирэмсэн эхийн- 2, хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдах шинээр төрсөн 3 хүүхэд, Цалинтай эхэд 3 эх , тэтгэвэр тэтгэмжинд сунгалтаар 3 иргэн тус тус хамрагдсан байна.

Төсөл хөтөлбөрт хамрагдсан 2020 оны үлдэгдэлтэй хүмүүст албан бичиг хүргүүлж гарын үсэг зуруулж төлбөрийг нэхэмжлэн ажилласан. Малжуулах хөтөлбөрт хамрагдсан болон ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдээс нийт 8,640,000 төгрөгийг төрийнд санд төвлөрүүлсэн байна.

ОНОТ төсөлд зорилтод өрхийн 3 төсөл, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 2 төсөл, Малжуулах төсөлд 3 төсөл, Нийтийг хамарсан ажилд 1 төсөл хүлээн авсан. Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар ОНОТ төсөлд дэмжигдсэн төслүүдийн холбогдох материалыг Хөдөлмөр эрхлэлт, халамж үйлчилгээний газарт хүргүүллээ.

Бүлгээр ногоо тарих төсөлд Засаг даргын нөөц хөрөнгөөс 80кг үрийн төмсний 72000 мянган төгрөгийг шийдвэрлэж Зорилтот өрхийн 3 өрхөд үрийн төмсийг олгож тариалах ажлыг эхлүүлсэн.

Мал эмнэлгийн чиглэлээр: Хувийн хэвшлийн малын эмч нар Аймгийн мал эмнэлгийн газар, Сумын засаг даргатай гурвалсан гэрээг байгуулж 2021 онд хийх ажил үйлчилгээний хуваартай танилцлаа.

5 сарын 12 ны өдөр сумын 4-р багийн харьяат иргэнээс ирсэн дуудлагын дагуу аймгийн мал эмнэлгийн 2 мэргэжилтэн , Хувийн хэвшлийн малын эмч, тасгийн хоёр мэргэжилтэн нар тухайн хотонд ажиллалаа. Тухайн айлын дуудлага шүлхий өвчин болох нь урьдчилсан оношоор баталгаажиж тухайн орчинд хязгаарлалтын дэглэм тогтоож сумын засаг даргын 5 сарын 14 ны өдрийн А 53 тоот захирамж гарсан.

5 сарын 18 ны өдөр улсын төв лаборатороос ирсэн хариуг үндэслэн Сумын хэмжээнд хэсэгчилсэн хөл хорио тогтоож засаг даргын А/58 дугаар захирамжийн дагуу багийн даргаар ахлуулсан хөдөлгөөнт пост 2 гарч баяндэлгэр сумаас орох төв зам дагуу 2 малчин, зүүн талаас онгоны их зам дагуу 3 малчин хөдөлгөөнт, суурин постод ажиллаж байна.

Хөдөө аж ахуй чиглэлээр : Бог малын 2 сууриар орж өсвөр насны хээлтүүлэгч тавьлаа.

ЖДҮ, СХСангийн чиглэлээр: 2021 оны 04-р сарын 23-ноос 05-р сарын 20-ны байдлаар нийт 17 зээлдэгчийн эргэн төлөлтийн орлого 14 хүнээс 6,648,447 мянган төгрөгний орлого Сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Газар тариалангийн чиглэлээр: тариалан эрхлэгч ААН, байгууллага, иргэдээс үрийн төмсний захиалга аван Сүхбаатар аймгийн төвөөс 15 ширхэг шуудай буюу 600кг үрийн төмс татан авчраад тараах ажил хийгдэж байна.

Байгаль орчны чиглэлээр: Нийтийн эзэмшлийн гудамж талбайд их цэвэрлэгээ зохион байгуулав. Үүнд : 6 албан газар, ард иргэд 114 иргэн оролцож 5 тонн ахуйн хог хаягдлыг цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлэв.

Залуучуудын санаачлагаар Самын булаг болон Сүмийн булгийн ойр орчимд их цэвэрлэгээ зохион байгуулж 3 тонн хогийг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэв.

Мод тарих үндэсний өдрөөр 6 албан байгууллага, 64 иргэн 450 ширхэг хайлаас мод тарив.

Хог хаягдлын хураамж тогтоох тухай тогтоолын төслийг Сумын ИТХ-д өргөн барьж батлуулав.

Газар зохион байгуулалтын чиглэлээр: Газрын кадастрын мэдээллийн сангаас 4 иргэний кадастрын зураг хэвлэж ажилласан. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийх компани тус суманд 2 хоног ажиллав.

Уулбаян:

20 иргэний өргөдлийг бүртгэлд хүлээн авч шийдвэрлэсэн байна.

2021 оны 5 дугаар сарын байдлаар шинээр төрсөн -57, үүнээс эрэгтэй – 13, /ковидтой холбоотой хугацаа хэтэрсэн төрөлт-3/, ургийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл-2, үрчлэлт-1, нас барсан-18 үүнээс эрэгтэй-3, гэрлэсний бүртгэл-24, цахим иргэний үнэмлэх захиалсан– 29, цахим иргэний үнэмлэх сунгалт хийлгэсэн– 25, 45 насны- 59, эцэг, эх тогтоолгосны бүртгэл – 7 тус тус бүртгэгдсэн байна.

Төсөв санхүүгийн чиглэлээр: Сумын хэмжээнд коронавирусын халдвар хамгааллын дэглэмийг сахиж ирлээ. Сум тойрсон хөдөлгөөнт эргүүлийг 50 хоногийн хугацаанд /өдрийн 1 машинд 15л шатахуун/, тэгш багт өвчлөл гарсан айлд хяналт тавихад зориулж 3 газарт 6 төрийн албан хаагч 3 машин тус тус гарч 1 машинд 40 л шатахуун, өдрийн 4 машин гарч нийт 15030,0 мянган төгрөгийн шатахууны өр үүсээд байна. Халдвар хамгааллын хувцас, ариутгалын бодис, 5200,0 төгрөгийн зардал гарч, 4700,0 мян төгрөгийн нөөцийг бүрдүүлээд байна. Тусгаарлах байрны бэлэн байдлыг ханган Улсын онцгой комиссын 31 дугаар тушаалын дагуу тусгаарлан ажиглах байрны шаардлагыг ханган ажиллаа.

Худалдан авах ажиллагааны талаар: Нийтийн халуун усны цахим тендерийг зарлаад байна.

4 айлын газар чөлөөлөх комиссыг томилж иргэдийн иргэдэдтэй зөвшилцсөний үндсэн дээр газар чөлөөлөх гэрээг байгуулав.

Жишиг хороололын ундны усны худагт автомат төхөөрөмж /ухаалаг худаг/ байгуулах гэрээг хийж гүйцэтгэв.

Байгаль орчны чиглэлээр:Монгол Улсын Ерөнхийлөгчийн 63 тоот зарлигийн хүрээнд “ӨРХ БҮР 3-н МОД ТАРЬЯ” уриатайгаар зохион байгууллаа. Боловсролын 100 жилийн ойг угтан Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг нийтийн эзэмшлийн талбайд мод тарьж байгаа бөгөөд уг ажлыг орон нутгийн зүгээс дэмжин 262ш улиас, хайлаас, буйлс, монос модны дэмжлэг үзүүлсэн. Мөн нийтийн эзэмшлийн талбайн нөхөн сэргээлтээр 40ш улиас, буйлс, шинээр 50ш монос, айл өрхүүд 150ш монос, үхрийн нүд, аж ахуй нэгж байгууллагууд 256 зэрэг нийт 758ш модыг тариад байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 сарын 03-ны өдрийн 211 тоот тогтоолын дагуу ус, дулааны үнийг төлбөрөөс чөлөөлсөнтэй холбогдуулан 2021 оны 4 сарын усны төлбөр болох 1993800 төгрөгийг сумын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэнийг 4 газарт буцаан олголт хийсэн.

“Хоггүй цэвэрхэн – Уулбаян сум” уриан дор малын сэг зэм, эзэнгүй хог хаягдалыг цэвэрлэх ажлын хүрээнд Мал эмнэлэгийн тасагтай хамтран Жавхлант багийн нутагт үүссэн хог хаягдлыг “Сунхун гоулд” ХХК-тай хамтран зохион байгуулж 0,2 га талбайг хогийг дарж, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийсэн.

Ковид – 19 өвчин гарсантай холбогдуулан нийтийн эзэмшлийн талбайн ариутгал халдваргүйжүүлэлтийг мал эмнэлэгийн тасагтай хамтран 16,800 м² талбайд хийсэн.

Засгийн газрын 2016 оны 179-р тогтоолыг чиглэл болгон Нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээг 2021 оны 05.18-нд “Эм Эл цахиурт овоо” ХХК аймаг, сумтай хамтран ажиллах гэрээг байгуулж тус бүр 50,0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр болсон.

Газар зохион байгуулалт: Ул хөдлөх хөрөнгийн гэрчилгээ авахаар материал бүрдүүлж байгаа 2 иргэнд кадастрын зураг болон холбогдох бусад мэдээллийг бүрдүүлж өгөв. Хэмжээ талбай зөрүүтэй 2 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг шинэчилж

шинэчилж гаргасан. Сумын төвийн ногоон байгууламж ус усалгааны машиныг эзэмшихээр болсон иргэнд хүлээлгэн өгч гэрээ байгуулав.

Баян баг, Жаргалант баг, Жавхлант багуудаар явж сэг зэмийн устгалыг хийж гүйцэтгэлээ.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Сумын хувьд 106959 хээлтэгчээс 84996 нь буюу 79.5% нь төллөөд байна. Үүнээс ингэ-136, гүү-3506, үнээ-3522, эм хонь-50593, эм ямаа-27239 төллөөд байна. Нийт 69415 төл хүлээж авснаас төлийн бойжуулалт 100%-тай байна.

Хүнс, худалдаа, үйлчилгээ чиглэлээр: Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний бодит нөөцийн судалгаа 2021 оны 5 сарын 20 байдлаар.

Бүтээгдэхүүний нэр	Нөөц
Гурил	13 тн
Гурилан бүтээгдэхүүн	470 ш
Будаа	425 кг
Хуурай/Шингэн сүү	285ш
Өндөг	730ш
Ургамлын тос	156ш
Төмс	422кг
Хүнсний ногоо	105кг
Элсэн чихэр	395кг
Давс	221кг
Савласан ус	294ш

Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөц болон татан авалтын хомсдол үүсээгүй, хүнсний тээвэрлэлт хэвийн явагдаж байна.

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг /улбар шар/-т шилжүүлсэнтэй холбогдуулан худалдаа үйлчилгээний ажиллах 08:00-22:00 цагийн хооронд тогтоон аж ахуйн нэгж байгууллагыг халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж ажиллахыг үүрэг болгосон.

Түлшний нөөцийн хувьд хэвийн хомсдол үүсээгүй.

№	Байгууллагын нэр	А-80	А-92	ДЗ
1	“Байшинт Ойл” ХХК	18тн 600л	5тн 200л	13тн 800л

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй байхыг 2021оны 4сарын 11 өдөр аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт мэдэгдэл хүргүүлж, хууль тогтоомж зөрчих, мэдэгдлийн хэрэгжилтийг хангахгүй зөрчил гаргавал Зөрчлийн тухай хуулийн дагуу 5.13 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага оногдуулахыг мэдэгдсэн.

Коронавируст халдвар цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 05 сарын 8-9 хооронд жижиг дунд үйлдвэрлэл, эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагын 33 иргэнийг 1-р тунгийн вакцинжуулалтад хамруулах ажлыг зохион байгууллаа.

Гэрийн ажиглалтад байгаа иргэдэд хяналт тавих ажлын хэсэгт ажиллаж байна. Халдвартай бүс нутгаас ирж байгаа иргэдийг гэрийн ажиглалт болон тусгаарлалтад 7 хоног байлган мэргэжлийн байгууллагаас өгсөн зөвлөмж зөвлөгөөг хүргэн, хяналт тавин ажиллаж байна.

2021.05.22-ны байдлаар 2011-2020 оны хооронд зээл авсан 30 зээлдэгчийн 248,800,000 төгрөгийн зээл олгосон байна. Бодогдсон хүү нь 13,627,342 төгрөг. Үүнээс, зээлийн хүү, алданги ороод 115,442,314 төгрөг эргэн төлөгдсөн. Нийт үлдэгдэл 146.625.028 төгрөг байна.

Зээлийн хэлбэр	Зээлдэгч	Зээлийн дүн
Хэвийн зээл	10 зээлдэгч	70,000,000
Эргэлзээтэй зээлтэй	/181-360хоног/ 5 зээлдэгч	47,000.000
Муу буюу чанаргүй зээлтэй	/360≥/ - 15 зээлдэгч	131,800,000
Хаагдсан зээл	7 зээлдэгч	48,287,470,

Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь 63.7% байна. 4 сарын 30 байдлаар зээлийн эргэн төлөлтөөр 9,813,048,00 төгрөг сум хөгжүүлэх санд орж ирсэн байна.

Мал эмнэлгийн чиглэлээр: Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Сун хун голд уурхайн техникийг ашиглан сумаас зүүн хойш засмал замын карерийн нүхэнд хийсэн хог хаягдал, 15 бод 60 гаруй бог малын сэг зэмийг булж устган халдваргүйтгэл арга хэмжээ зохион байгууллаа.

05 сарын 03 ны өдөр 5-р багийн малчин Г-ээс ишиг өвчилсөн тухай дуудлага ирсний дагуу үзлэг хийн дээж материал авч, аймгийн Мал эмнэлгийн газрын лабораторид хүргүүлэхэд шөвөг яр өвчин болох нь тогтоодсон. Үүний дагуу тус малчны малд шөвөг ярын вакцин тарьж, хотонд нь халдваргүйтгэлийн арга хэмжээ зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласнаар өвчлөл зогссон.

Тус суманд мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхэлж байгаа хувийн мал эмнэлгүүдийн гурвалсан гэрээг сумын Засаг даргаар баталгаажуулан, аймгийн Мал эмнэлгийн газарт 2 хувийг хүргүүлээд байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт: Нийтийг хамарсан 3 төсөл хүлээн авч аймаг явуулсан.

2021 оны 05 сард Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд жирэмсэн эхийн тэтгэмжинд 5 иргэн, цалинтай эхийн тэтгэмжинд 2 иргэнийг, бүртгэсэн. Хүнсний талоны 42 өрхөөс 40 өрхийн хүнс тэжээлийг олгосон. Мөн 42-41 өрхийг коджуулсан. Шинээр төрсөн 3 хүүхдийн бичиг баримтыг хүлээн авч бүртгэсэн.

Нийгмийн даатгал: Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 203516.9 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ. Сайн дурын даатгалд 156 даатгуулагчидтай шинээр гэрээ байгуулан 21531 мян төгрөгийн шимтгэл, Эрүүл мэндийн даатгалд 120 даатгуулагчийг даатгаж 7697 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн.

Шинээр өндөр насны тэтгэвэр -18, тахир дутуугийн тэтгэвэр-1, тэжээгчээ алдсаны тэтгэвэр -2 нийт 21 тэтгэвэр, 2 тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн, 7 даатгуулагчдад ажилгүйдлын тэтгэмж тогтоогоод байна.

Тус хугацаанд тэтгэвэр тогтоолгох өргөдөл-21, тэтгэвэр авах зөвшөөрөл-5, Банк солих-2, тэтгэмж-10, ажилгүйдлын тэтгэмж-7 малчнаар ажилласан жил тотоолгох-6 нийт 51 өргөдлийг хүлээн авч бүрэн барагдуулж, 440 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргээд байна.

Нийгмийн бодлогын чиглэлээр: Сумын албан байгууллага, аж ахуй нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлд аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсээс цахим

сургалтыг хийсэн. Сургалтаар эцэг эхийн зөвлөлийн хийж хэрэгжүүлэх ажлын чиг үүргийн талаар танилцуулж үүрэг чиглэл өглөө.

Сумын залуучуудын салбар зөвлөлийг шинэчлэн байгууллаа. Зөвлөлийг 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтсээс сургалт авч гишүүдийг хамрууллаа.

Гэр бүл хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хамтарсан баг хуралдлаа.

Хүүхдийн өөрийн удирдлагын болон хөгжил оролцооны байгууллагуудын “Оролцоод хөгжье” цахим чуулганд сургуулийн нийгмийн ажилтан, 10 хүүхдийн хамт оролцуулсан.

Сумын ахмадын хороо аймгийн ахмадын байгууллагын 90 жилийн ой угтсан цахим дуу шүлгийн уралдаанд ахмад настнууд оролцсон.

Эрүүл мэнд:

	Нэрс	Тоо
1	Урьдчилан сэргийлэх үзлэг	1734
2	Амбулаторийн үзлэг	796
3	Гэрийн дудлага	169
4	Алсын дуудлага	103
5	Артерийн даралт	459
6	Чихрийн шижин	586
7	Хөхний үзлэг	381
8	Эсийн шинжилгээ	9
9	0-2 насны хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилга	108
10	Ковид-19 дархлаажуулалт вакцинд хамрагдсан	113
11	Гэрийн тусгаарлалтад байгаа	18
12	Гэрийн ажиглалтад байгаа	6

Ерөнхий боловсролын сургууль : “Арч Хур” сургалтын байгууллагаас Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 21 хоногийн цахим сургалтад ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан хамрагдсан.

23 багш мэргэжлийн чиглэлээр давхардсан тоогоор 138 цахим сургалтад хамрагдсан байна.

Хүүхдийн цэцэрлэг: Багш нар хүүхдүүдтэйгээ утасаар болон цахимаар байнга холбогдож уялдаа холбоотой ажиллаж байна. Мөн бүлгийн багш нар хүүхдүүдээ цахимаар 10, цаасаар 266 ширхэг даалгаварыг хүргэж ажилаад байна. Багш, туслах багш нар гэрээр бүх бүлгийн “Теле хичээл”-ийг үзэж тэмдэглэл хөтлөн ажиллаж байна. Теле хичээлийн хамрагдалт 83,7%-тай байлаа. Мөн 5 настай 54 хүүхэд бэлтгэл бүлгийг төгслөө.

Багш ажилчид сумын нийтийн эзэмшлийн газарт 108ш мод тарилаа. Мөн байгуулгын ажилчдад гэр бүлийн гишүүдийн тоогоор хашаандаа мод тарьж эхлээд байна.

Соёлын төв: Нийтийн номын сан цахим орчинд нутгийн ахмад үеийн тэргүүний малчдын туршлагаас цувралаар хүргэлээ. Мөн ардын аман зохиол, үлгэр, шилдэг бүтээлүүдээс толилуулж нийт 1696 хандалт авсан бна.

Түүх соёлын үл хөдлөх дурсгалуудад тандалт судалгаа хийх, иргэдэд гэрээгээр хариуцуулах бэлтгэл ажил хангагдаад байна.

Хууль, эрх зүйн чиглэлээр: Засаг даргын тамгын газраас долоо хоногийн 1, 3, 5 дахь өдрийг “Хууль зүйн зөвлөгөө мэдээллийн өдөр” болгосон бөгөөд өөрсдийн болон бусад төрийн байгууллагын бэлгэтсэн хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн эх сурвалжийг дурдаж мэдээллийг “Уулбаян сумын Засаг даргын Тамгын газар” гэсэн цахим хуудсаар тогтмол хүргэж байна. Мөн төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй, мэдээллийг тогтмол хүргэж байхыг чухалчлан “Сүхбаатар аймгийн Уулбаян сумын албан ёсны мэдээ, мэдээллийн нэгдсэн групп”-ийг нээн түүгээр мэдээлэл хүргэж байна.

2021 оны 05 дугаар сарын 21-ны өдөр “Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн өдөр”-ийг тохиолдуулан “Гэр бүлийн тухай хууль”, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, “Зөрчлийн тухай хууль”, “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль” зэрэг хууль зүйн сурталчилгаа, мэдээллийг олон нийтэд хүргэлээ.

Төрийн албан хаагчдад мэргэжил, ур чадвар дээшлүүлэхэд чиглэсэн “Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ” сургалтад Тамгын газар болон төсөвт байгууллагын нийт 24 албан хаагч хамрагдсан.

Хууль зүйн дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад Тамгын газрын дарга, Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн нар 04 дүгээр сараас эхлэн суралцаж байна.

“Засгийн газрын хэрэг эрхлэх газраас аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга нарын нэгдсэн уулзалтын хүрээнд даалгасан ажлыг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан. Тус төлөвлөгөөний дагуу тамгын газар болон бусад төсөвт байгууллагын албан хэрэг хөтлөлтийн байдалд үзлэг хийж, шалгалтыг хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн хариуцан зохион байгуулж, дүгнэлт, зөвлөмж гаргав. Ковид-19-н нөхцөл байдлаас шалтгаалан 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдөр Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, төсөвт байгууллагын дарга, эрхлэгч нарт хүргүүлэв.

Шинээр томилогдох дөрвөн багийн Засаг даргын хөрөнгө орлогын урьдчилсан мэдүүлгийг авилгалтай тэмцэх газарт хүргүүлсэн бөгөөд намын харьяалал, төрийн албан хаагчийн анкет, ажилд томилогдсон тушаал, шийдвэрийг хугацаанд нь явуулсан.

Сумын Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/44 дүгээр захирамжаар “Гэрийн тусгаарлалт, ажиглалад байгаа иргэдэд хяналт тавих ажлын хэсэг” байгуулан хэсгийн ахлагчаар хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн ажиллаж байна. Тус ажлын хэсэг нь гэрийн тусгаарлалт, ажиглалтад байгаа иргэдэд зөвлөмж, баталгаажилтын хуудас, хууль, дүрмийг бэлтгэн өгч, өдөр бүр ярьж биеийн байдлыг үзэж байна. Өнөөдрийн байдлаар гэрийн тусгаарлалт, ажиглалтад иргэн байхгүй байна.

2020 оны 5 сарын байдлаар хулгайлах гэмт хэрэг-1, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих-7, танхайрах-2 тус тус гэмт хэрэг, зөрчил гарсан байна.

Эрдэнэцагаан:

Хууль эрх зүй удирдлага зохион байгуулалтын хүрээнд: Ерөнхийлөгчийн сонгуулийн ажлын бэлтгэл ажлын хүрээнд сумын сонгуулийн хороо болон хэсгийн хороодыг байгуулан нийт 77 албан хаагчид томилогдон бэлтгэл ажлаа хангаж байна.

Татвар, Нийгмийн даатгалын хүрээнд: Суурь тойрч багт ажиллах бүлгийг Нийгмийн даатгал, Татварыг байцаагч, Эмч, Багийн Засаг Дарга, байгаль хамгаалагч нарыг оролцуулан томилж хөдөөгийн 3 багийн 255 айл өрхөөр орж цаг үеийн ажлын талаар мэдээлэл хийж, Нийгмийн даатгалын шинэчлэгдсэн хууль, малчны тэтгэврийг сурталчилах, Сайн дурын хамрагдалтыг нэмэгдүүлэх, Малын хөлийн татварыг сурталчлах, орлого төвлөрүүлэх, гал түймрээс урьдчилан сэргийлэх, байгаль хамгаалах, иргэдийн эрүүл мэндэд үзлэг хийх чиглэлээр ажиллууллаа.

Нийгмийн хамгааллын хүрээнд: Хямралыг урьдчилан харж, бэлтгэлтэйгээр даван туулья-ХАБЭА-н тогтолцоог бэхжүүлэе уриан дор “Хөдөлмөрийн аюулгүй байдал-Эрүүл ахуй сарын аян-2021” аяныг иргэдэд цахимаар 14 хоног мэдээ мэдээлэл өгч ажилласан нь аймагт 1 дүгээр байранд орж шагнуулсан байна.

Байгаль хамгааллын хүрээнд: Багийн засаг дарга нартай хамтарч түймэр гарах эрсдэлтэй саруудад ард иргэдийг сонор сэрэмжтэй байлгах үүднээс хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх заавар зөвлөгөөтэй гарын авлага тарааж, гарын үсгийн баталгаа авч ажилласан. Нийт 480 ширхэг гарын авлага тарааж, 480 өрхөөс гарын үсгийн баталгаа авч ажилласан байна.

Хог хаягдал агаар бохирдуулагчийн чиглэлээр: Сумын төвийн бүх айл өрхийг сумын онцгой комиссын 39 гишүүнд хувааж өгч айл өрхүүдийг болон албан байгууллагуудыг

эргэн тойрныг нь цэвэрлүүлж ажилласан. Сумын нэгдсэн хогийн цэгийг цэгцлэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Нийт 8 га талбай бүхий газар тархаад байсан хогийг ковшуар түрж цэгцэлж 350 тонн хогийг булшилсан байна. Тус ажлыг хийж гүйцэтгэхэд нийт 4,5 сая төгрөгний зардал гарсан байна. Мөн сумын бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж төрийг болон төсвийн 10 байгууллагын 290, аж ахуй нэгж, дэлгүүр хоршоодын 20 бүгд 310 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан.

Мод, ногоон байгууламжийн чиглэлээр: Бүх нийтээр мод тарих ажлын хүрээнд 1 га талбай бүхий газар урьдчилсан байдлаар 1280 ширхэг мод тарьж бүрэн хашаа татаж хамгаалж ажиллаа.

Мал эмнэлгийн үйлчилгээ: сумын засаг даргын 2021 оны А/93 тоот захирамжаар галзуу өвчин гарсан хот айлын голомтоос гадагш эргэн тойронд 10 км-ийн радиустай нутаг дэвсгэрт 14 хоногийн хугацаатай дагуу хязгаарлалтын дэглэм тогтоон, 2021 оны 05 сарын 18-ны өдрөөр А/109 тоот захирамжаар хязгаарлалтыг цуцлан тухайн өрхөд ариутгал халдваргүйтгэлийг хийж ажилласан.

Сэг зэмийн устгал нийт 534 малд хийгдээд 46,3%-тай явагдаж байна.

Соёлын хүрээнд: Дэлхийн номын өдрийг угтуулан Соёлын төвийн дэргэдэх Гүндсамбуугийн нэрэмжит нийтийн номын сангаас -Монголын нууц товчоог хэн сайн мэдэх вэ? Тэмдэглэл хөтлөх уралдаан, “Монгол бичиг мину” цэвэр бичигтэн шалгаруулах, Монгол бичиг зурагт хуудас г.м олон олон уралдаануудыг зохион байгууллаа. Хүүхэд багачуудад ББӨ-ийн аман уламжлалын төрлүүдийг сурталчилан түгээн дэлгэрүүлэх, таниулах зорилгоор Дэлхийн музейн өдөр, эх үрсийн баярыг тохиолдуулан “Би ерөөлч хүүхэд” цахим уралдааныг зохион байгуулаад байна. Тэмцээнд 9 хүүхэд бүтээлээ ирүүлэн цахим орчинд байрлуулсан.

4-р багийн нутаг Хонгор гэдэг газраас ясан олдвор олдсоныг ажлын хэсэг газар дээр нь ажиллан сумын цагдаагийн газарт уг олдворуудыг хүлээлгэн өгч, холбогдох байгууллагуудаас заавар зөвлөгөө авч ажилласан. Энэ сард номын сангаар 12 хүн үйлчлүүлж, гэрээг 7 ширхэг ном олгон ажиллалаа.

Хүүхдийн 2-р цэцэрлэг: Хорио цээрийн дэглэмтэй хугацаанд суралцагчдад цахим сургалтын үйл ажиллагааг явуулж, хүүхэд багачуудад зориулсан зөвлөгөө зөвлөмж, цахим гэрийн даалгавруудыг хүргэж ажилласан. Мөн багш нар хичээлийн хэрэглэгдэхүүн 50 ширхэг, тараах материалуудыг 150 ширхгийг хийсэн байна.

Бүлгийн багш нар ирэх хичээлийн жилд мөрдөгдөх хичээлийн агуулгыг шинэчлэн боловсрууллаа. Дээд газраас зохион байгуулагдсан цахим сургалтуудад давхардсан тоогоор 120 багш ажилтан хамрагдсан байна.

Цэцэрлэгийн хашаанд улиас мод 100 ширхэг, агч мод 50 ширхэг, чацарганы мод 150 ширхэг, хайлаас 150 ширхгийг тарьж ургуулж байна. Хүүхдийг эрүүл хүнсээр хангах зорилгоор байгууллагын хашаанд 0,3 га талбайд төмс хүнсний ногоо, 4х6 харьцаатай хүлэмж байгуулан 10 төрлийн нарийн ногоог тарьж ургуулж байна.

ЕБС: Дэлхийн том хичээл “Тогтвортой хөгжлийн боловсрол” үндэсний хэлэлцүүлгийн хүрээнд зарлагдсан хичээл төлөвлөлтийн уралдаанд 400 гаруй хичээл өрсөлдсөнөөс 7 хичээл шилдэгээр шалгарч тус сургуулийн бага ангийн заах аргын нэгдлийн багш нарын “Хоггүй аялцаагай” сэдэвт хичээлийн төлөвлөлт шилдэг 7-д багтаж улмаар тогтвортой хөгжлийн боловсролын хичээлийн санд бүртгүүлэн үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхээр болсон.

ГБЗХГ, БСУГ-аас хамтран зохион байгуулсан Хүүхэд хамгааллын чиглэлээр анги удирдсан багш нарт зориулсан цахим сургалтанд 41 бүлгийн анги удирдсан багш болон сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрын багш нар хамрагдсан.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Сайхан бичигтэн -2021” цахим уралдаанд амжилттай оролцож эхний 3 байр эзэлсэн. Титэм арт академийн харъяа Аригүн каллиграфиас санаачилсан АЗДТГ, БСУГ-аас хамтран зохион байгуулсан “Жаахан шаргын нутаг” монгол бичгийн хичээнгүй бичгийн уралдаанд Монгол хэл бичгийн багш

М.Мөнхнарангийн удирдсан баг /багш нар/ 3-р байр, таталган бичлэгийн төрөлд М.Мөнхнаран багш 3-р байр эзэллээ.

Хүүхдийн өөрөө удирдлагын болон хөгжил оролцооны байгууллагуудын “Оролцоод хөгжье” цахим чуулганд 5 сурагч сургуулиа төлөөлөн сурагчдынхаа дуу хоолой болон оролцсон.

ХАА: Мал төллөлт 84%-тай байна. Тамгын газрын төмс хүнсний ногоог 1-га талбайд тариалсан. Үрийн төмсийг захиалан авчирч иргэд байгууллагад өгсөн. Урьдчилсан байдлаар төсвийн 4 байгууллага, 1 ААН, 5 өрх, бүгд 5 га-д төмс, 2 на-д хүнсний ногооны тариалалт хийгээд байна.

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар